

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ
ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ-2022**

**ИРГЭДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Захиалагч байгууллага: Цагдаагийн ерөнхий газар

Судалгааны баг: “Ажиглалт” НҮТББ

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Бодиз-Автомотив 303А, Улаанбаатар 14240
Монгол Улс
Утас: 9099-4959
email: ajiglalt@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

АГУУЛГА

НЭГ.УДИРТГАЛ.....	3
1.2.Судалгааны ажлын зорилго, зорилт	3
1.2.Судалгааны ажлын зорилго, зорилт	3
1.3.Судалгааны ажлын онцлог	3
1.4.Судалгааны арга зүй	3
1.5.Судалгааны түүвэрлэлт.....	4
1.6.Мэдээлэл боловсруулалт.....	4
1.7.Судалгааны хамрах хүрээ, хязгаарлалт.....	4
1.8.Судалгаанд хамрагдсан иргэдийн ерөнхий статистик мэдээлэл.....	5-6
ХОЁР.ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ҮНЭЛСЭН ТАЛААР.....	7
2.1.Хүний нөөцийн чиглэлээр.....	7-9
2.2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлийн талаар.....	9-10
2.3.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр.....	11-13
2.4.Алба хаагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр.....	13-18
2.5.Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах.....	18-21
ГУРАВ.ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД ХЭРЭГЖИЖ БУЙ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ.....	21
3.1.“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан арга хэмжээ.....	21-25
3.2.Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт.....	25-40
ДӨРӨВ.ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ТАЛААР.....	40
4.1.Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаар сэтгэл ханамжийн үнэлгээ.....	40-43
ТАВ.ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН ХАРИЛЦААНЫ СОЁЛ, ЁС ЗҮЙН ТӨЛӨВШИЛ	
5.1.Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшилтийн талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ.....	43-46
ЗУРГАА.ГЭМТ ХЭРГЭЭС СЭРГИЙЛЭХ ЕРӨНХИЙ ХАНДЛАГА.....	46-47
6.1.Нийт судалгаанд хамрагдсан 480 иргэдийн санал асуулгын дүн	
ДОЛОО.ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ СЭТГЭЛ ХАНАМЖ	
7.1.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны сэтгэл ханамжийн судалгаа.....	47-48
НАЙМ.ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	48-50
ЕС.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	50-51

НЭГ.УДИРТГАЛ

1.1.Судалгааны үндэслэл, шаардлага

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д зааснаар төрийн захиргааны байгууллага нь жил бүр хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх ёстой. Энэ журмын хэрэгжилтийг хангахын сацуу өмнөх жилүүдэд хийгдсэн хэрэглэгчийн үнэлгээний судалгаанд дурдсан дүгнэлт, зөвлөмжийн биелэлтийг хянах, байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийг тогтмол сайжруулах шаардлага нь энэхүү судалгааг явуулах гол үндэслэл, хэрэгцээ шаардлага болж байна.

1.2.Судалгааны ажлын зорилго, зорилт

"Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д "хэрэглэгчийн үнэлгээ" гэж захиргааны байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс авсан сэтгэл ханамжийн судалгааг хөндлөнгийн байгууллагаар хийлгэсэн дүнг хэлнэ гэж заасан. Энэхүү хэрэглэгчийн үнэлгээний судалгаа (цаашид "судалгаа" гэх)-ны зорилго нь Цагдаагийн ерөнхий газрын хуулиар тогтоосон чиг үүргийн хэрэгжилтийг хөндлөнгийн байр суурьнаас үнэлэх, үнэлгээний үр дүнд суурилан үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулах санал, зөвлөмж боловсруулахад оршино.

1.3.Судалгааны ажлын онцлог

Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээг тодорхойлох зорилгоор өмнө нь явуулсан судалгаа нь ихэнх тохиолдолд Улаанбаатар хотын иргэдийн дунд явуулдаг байсан бол энэ удаа нийслэлийн 6 дүүрэг, 4 аймгаас түүвэрлэн цахим сүлжээ болон өөрсдийн орон нутгийн зарим судалгааны байгууллагыг түшиглэн ажиллалаа. Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний асуулгыг боловсруулахдаа түгээмэл хэрэглэдэг аргачлалд тулгуурлан боловсруулсан, судалгааны үр дүнг Улаанбаатар хотын дүүрэг, судалгаа хийгдсэн аймаг тус бүрээр нь гаргаж, дундаж оноогоор нь эрэмбэлэн харуулсан болно.

1.4.Судалгааны арга зүй

Энэхүү ажлыг хийж гүйцэтгэхдээ санал асуулга, ярилцлагыг хэрэглэсэн бөгөөд санал асуулгын хуудсыг түгээмэл хэрэглэдэг аргачлалд тулгуурлан 6 бүлэг 36 асуулттайгаар боловсруулж, үзүүлэлт бүрийг 5 хүртэл оноогоор үнэлж, хэрэглэгчийн үнэлгээний түвшинг бүлэг тус бүрээр болон нэгдсэн дүнгээр тодорхойлов.

(Хавсралт-2)

1.5. Судалгааны түүвэрлэлт

Судалгаанд нийт 608 иргэд хамрагдсан ба аймаг, дүүрэг тус бүрээс 60 иргэн буюу нийт 4 аймгийн 120 иргэн, 6 дүүргийн 360 иргэн судалгаанд оролцож шаардлага хангаагүй 128 саналын хуудсыг хасаж тооцов.

Судалгааны түүвэрлэлтийг хийхдээ нийслэлийн 6 дүүрэг, 4 аймгийн төвийн 480 иргэнийг сонгож авсан бөгөөд 2022 оны эхний хагас жилийн байдлаар цагдаагийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэд байх гэсэн шалгуурыг удирдлага болгосон.

Түүвэрлэлтийн загвар			Хүснэгт №1
№	Дүүрэг, Аймаг	Судалгаанд оролцогчид	Нийт
1	Архангай	30	4*30=120
2	Баянхонгор	30	
3	Булган	30	
4	Хэнтий	30	
1	Баянгол	60	6*60=360
2	Баянзүрх	60	
3	Сонгинохайрхан	60	
4	Сүхбаатар	60	
5	Хан-Уул	60	
6	Чингэлтэй	60	
Нийт		480	480
<i>Жич: Шаардлага хангаагүй санлын хуудсыг хасаж тооцсон болно.</i>		128	-

1.6. Мэдээлэл боловсруулалт

Судалгааны мэдээллийг SPSS.21 програм дээр боловсруулж, тайланг хэрэглэгчдэд ойлгомжтой, хүртээмжтэй болгох үүднээс Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос эрхлэн гаргадаг “Монгол Улсын статистикийн эмхтгэл”-ийн аргачлалд тулгуурлан Улаанбаатар хот, 4 аймаг гэсэн ангиллаар судалгааны үр дүнг харуулж, харьцуулалт хийв. Үзүүлэлт бүрийн жигнэсэн дундаж, дээд, доод утга, медиан зэрэг статистик үзүүлэлтийг тооцохын зэрэгцээ, үзүүлэлтүүд хоорондын хамаарлыг статистик шинжүүрийн тусламжтайгаар тооцон тодорхойлж, зохих сорил шинжүүрээр шалгаж магадлав.

1.7. Судалгааны хамрах хүрээ, хязгаарлалт

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэх хэрэглэгчийн үнэлгээний судалгааг 4 аймаг, нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд хязгаарыг тогтоож, 2022 оны эхний хагас жилийн байдлаар цагдаагийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн дунд судалгааг явуулсан. Улаанбаатар хотын хэрэглэгчийн үнэлгээг тодорхойлох судалгаа хугацаанаас өмнө буюу хагас жилийн байдлаар хийж эхэлсэнтэй холбоотойгоор зөвхөн төвийн 6 дүүрэг, 4 аймгийн иргэдийг хамруулан судалгааг явуулсан.

1.8. Судалгаанд хамрагдсан иргэдийн ерөнхий статистик мэдээлэл

Шинж байдал, хувийн жингээр


Хүснэгт №2

Үзүүлэлт	Шинж байдал	Давталт	Хувь
Хүйс	Эрэгтэй	205	42.7
	Эмэгтэй	275	57.3
Гэрлэлтийн байдал	Гэрлээгүй	112	23.3
	Гэрлэсэн	368	76.7
Нас	24 - доош	48	10.0
	25 - 34	186	38.8
	35 - 44	149	31.1
	45 – 54	57	11.8
	55 – дээш	40	8.3
Боловсролын байдал	Боловсролгүй	20	4.1
	Бага	37	7.7
	Бүрэн бус дунд	107	22.2
	Бүрэн дунд	104	21.6
	Дээд	212	44.1

Эх үүсвэр: Судлаачийн SPSS 21 програмаар тооцсон дүн

Судалгаанд оролцогсдын хүйс, хувийн жингээр


Зураг №1



Нийт судалгаанд оролцогчдын 205 буюу 42.7 хувийг эрэгтэй, 275 буюу 57.3 хувийг эмэгтэй иргэд эзэлж байна.

Гэрлэлтийн байдал, хувийн жингээр


Зураг №2



Судалгаанд хамрагдсан иргэдийн 76.7 хувийг гэрлэсэн, 23.3 хувийг гэрлээгүй иргэд эзлэж байна.

Насны бүлэг, тоогоор

Зураг №3



Судалгаанд хамрагдсан иргэдийг насны бүлгийн хувьд авч үзвэл 24 доош насны иргэн 48 буюу 10 хувь, 25-34 насны иргэн 186 буюу 38.8 хувь, 35-44 насны 149 иргэн буюу 31.1 хувь, 45-54 насны 57 иргэн буюу 11.8 хувь, 55 дээш насны 40 иргэн буюу 8.3 хувийг тус тус эзэлж байна.



Судалгаанд хамрагдсан иргэдийн 20 буюу 4.1 хувь нь боловсролгүй, 37 буюу 7.7 хувь бага боловсролтой, 107 буюу 22.2 хувь нь бүрэн бус дунд боловсролтой, 104 буюу 21.6 хувь нь бүрэн дунд боловсролтой, 212 буюу 44.1 хувь нь дээд боловсролтой байна.

ХОЁР.ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ҮНЭЛСЭН ТАЛААР

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2021 онд үйл ажиллагаанд холбогдох бодлогын 24, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 74, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 6 баримт бичиг, захиргааны хэм хэмжээний 10 акт болон биелэлт эргэн мэдээлэх шаардлагатай нийт 83 шийдвэрийн 143 арга хэмжээ, зүйл заалтыг хяналтад авч, биелэлт, үр дүнг тооцон, хяналт-шинжилгээ хийн, үнэлгээ өгч, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, дүгнүүлэхэд харьяа агентлаг, байгууллагуудаас нэгдүгээр байрт шалгарсан өндөр үзүүлэлттэй байна, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Хууль зүйн сайдын баталсан журамд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамнаас дараах 10 үзүүлэлтийн дагуу харьяа агентлаг байгууллагын тухай жилийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж байр эзлүүлдэг байна. 2020,2021 оны үзүүлэлт тус бүрт өндөр оноо авч Цагдаагийн ерөнхий газар тэргүүлсэн байна.

2.1.ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад 568 орон тоо нэмэгдүүлсэнийг хуваарилан, алба хаагчийг томилсон. Ингэж орон тоог нэмэгдүүлсэнээр нэг алба хаагчид оногдох ачаалал буурахад эерэг нөлөө үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 871, Дотоодын цэргийн командлагчийн 47, Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 20, Захиргааны удирдлагын газрын даргын 37, нийт 975 тушаалаар 5196 алба хаагчдын хүний нөөцийн асуудлыг шийдвэрлүүлсэн байна.

Соён гэгээрүүлэх албаны сургалтын чиглэлээр:

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны албаны болон давтан мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг алба хаагчийн ур чадвар, зөв дадал, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн чадамжид суурилсан сургалтыг явуулах үндсэн зарчмуудыг удирдлага болгон, Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн алба хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр”, хүний нөөцийн бодлого зэрэгтэй уялдуулан боловсруулж, цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/07 дугаар тушаалаар батлуулан Дэд даргын 3/18 дугаар албан бичгээр үүрэг, ажлын чиглэлийн хамт анги, байгууллагад хүргүүлж, биелэлт, үр дүнг 2022 оны эхний хагас жилийн байдлаар тооцон ажилласан байна.

Ажлын байрны /албаны/ сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 2929 удаагийн сургалт зохион байгуулж, 425.424 алба хаагчийг /давхардсан тоогоор/ хамруулж, 251 хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан, 195 аудио, видео бичлэг, богино хэмжээний кино бүтээж, 991 ширхэг гарын авлага, тараах материал, бодлого, аргачлал хэвлүүлэн тарааж, сургалтад нийт 19.6 сая төгрөг зарцуулсан байна.

Мөн цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд 2022 онд “Алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх давтан, мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөө”-ний дагуу 65 төрлийн 126 удаагийн сургалтын 97 нь танхимаар, 29 нь зайнаас болон цахимаар буюу Цагдаагийн байгууллагын сургалтын нэгдсэн сан “Moodle” программаар тус тус зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд энэ оны эхний хагас жилийн байдлаар 69 удаагийн сургалт зохион байгуулж, 1886 иргэн, 8527 алба хаагч, нийт 10413 алба хаагч, иргэнийг тус тус хамруулан, хөтөлбөр, төлөвлөгөө 70 хувьтай хангасан байна.

Өнөөдрийн байдлаар Цагдаагийн ерөнхий газрын захиалгаар Дотоод хэргийн их сургуулийн бакалаврын боловсролын сургалтад 2022 оны эхний хагас жилийн байдлаар өдрийн ангийн бакалаврын сургалт, 2 жилийн хөтөлбөрт 805 сонсогч, эчнээ 3 жилийн сургалтад 113, эчнээ 5 жилийн сургалтад 32, нийт 145 алба хаагчийг суралцуулсан байна.

Мөн Дотоод хэргийн Их сургуулийн 2021-2022 оны хичээлийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу “Гэмт явдал судлал-эрх зүй”, “Цагдаа судлал”, “Эрх

зүй” магистрын I, II дамжаанд суралцах 45 алба хаагч, докторын өдрийн ангийн сургалтад 1, улирлын сургалтад 7, нийт 8 алба хаагч тус тус суралцсан байна.

Магистрын хөтөлбөрийн I,II дамжаанд 45 алба хаагч, Удирдлагын сургуульд 13, докторантурын I, II дамжаанд 8 алба хаагч, нийт 66 алба хаагчийг тус тус суралцуулсан байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, АНУ-1, БНХАУ-1, ОХУ-71, БНТУ-10, Унгар-3, БНСУ-3, нийт 6 улсын цагдаагийн байгууллага, академи, их, дээд сургуульд боловсролын адъюнктур, доктор, магистрантур, бакалаврын сургалтад 89 алба хаагчийг суралцуулж байна.

Мөн алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр мэргэшүүлэх, зорилгоор 12 удаагийн богино хугацааны сургалтыг зохион байгуулж, 332 алба хаагчийг хамруулсан байна.

2.2.МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТАЛААР

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны 2021 оны тайланд дурдсанаар 2019 оны байдлаар дэлхийд 15-64 насны 275.0 сая хэрэглэгч бүртгэгдэж, 2030 он хүртэл орлогын түвшин бага, хөгжил буурай болон хөгжиж буй улс орнуудын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглэгч 43.0 хувиар өсөх хандлагатайг анхааруулсан.

Мөн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр Төв Ази, Латин Америк, Зүүн өмнөд Европын бага болон дунд орлоготой улс орнуудад амжилттай хэрэгжиж байгаа “Гэр бүлд суурилсан урьдчилан сэргийлэх”, “Сургуульд суурилсан мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ажиллахыг улс орнуудад зөвлөмж болгосон.

Сүүлийн 5 жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэрэгт холбогдогчдын 55.0 хувийг 13-25 насны хүүхэд, залуучууд эзэлж байгаа тул мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өсвөр насны хүүхэд залуучуудыг хорт зуршлаас ангид байлгах, тэдний эцэг эх, асран хамгаалагч, багш, нийгмийн ажилтнуудад мэдлэг олгох зорилгоор ухуулга нөлөөлөл, мэдээлэл, сурталчилгааны “Хасах 25” төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төслийг эрчимжүүлж, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулахаар нийслэлийн хэмжээнд “Анзаар” аян, арга хэмжээг энэ онд зохион байгуулахаар төлөвлөж, эхний хагас жилд Хан-Уул дүүрэгт “Хар тамхигүй дүүрэг”, Сонгинохайрхан дүүрэгт “Мэдээллээ сайжруулья, анхаарлаа хандуулья”, Чингэлтэй дүүрэгт “Нэг удаа гэж үгүй” уриатайгаар тус тус зохион байгуулсан.

Арга хэмжээний хүрээнд төрийн болон төрийн бус 118 байгууллагын 8046 ажилтан, 18 их, дээд сургуулийн 317 багш, 2795 оюутан, ерөнхий боловсролын 82 сургуулийн 1830 багш, нийгмийн ажилтан, 7569 эцэг, эх асран хамгаалагч, нийт 20557 хүнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, хэрэглэсэн хүнд илрэх шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар мэдлэг олгох сургалт, мэдээллийн ажлыг танхимаар зохион байгуулж, хор уршиг, үр дагавар, хууль эрх зүйн мэдээлэл өгөх агуулга бүхий 21300 ширхэг гарын авлага бэлтгэн тараасан байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ахуйн хэрэглээний газ, будаг шингэлэгч үнэрлэн мансуурдаг 85 хүүхдийн судалгааг гаргаж, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн төвийн сэтгэц, наркологийн эмч, сэтгэл зүйч нартай хамтран хүүхдүүд болон тэдний эцэг эх, асран хамгаалагч нарт зөвлөгөө, тусламж, үйлчилгээг үзүүлж байна.

Хүүхэд, залуучуудыг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглэгч, донтогч болохоос урьдчилан сэргийлэх, хэрэглэсэн хүүхдийг хяналтад авах зорилгоор 12 их, дээд сургуулийн 650 оюутан болон энэ төрлийн гэмт хэрэгт хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн, хугацаанаас өмнө суллагдсан 75 хүнээс биологийн дээж авахад зөрчил илрээгүй байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өсвөр үе, хүүхэд, залуучуудад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэхийг өөгшүүлэх, үйлдлийн аргыг ил, далд хэлбэрээр сурталчилсан дуу 11, кино 6, нэвтрүүлэг 4, нийтлэл, ярилцлага 14, нийт 35 мэдээллийг устгуулах арга хэмжээ авсан байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр 115 мэдээлэл, 36 зурагт хуудас, 20 видео бичлэгийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон Хар тамхитай тэмцэх газрын facebook, Instagram, Twitter, Youtube зэрэг цахим хуудсаар түгээснийг давхардсан тоогоор 5.2 сая хүн үзсэн байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргийн дуудлага, мэдээлэл хүлээн авах, тусламж үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх 116 тусгай дугаарын утсыг энэ оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс ашиглалтад оруулахаар бэлтгэл ажлыг ханган ажилласан байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас дэлхийн улс орнуудад бүх нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чухал арга замуудын нэг гэж тодорхойлсон.

Энэ чиглэлээр олон улсын туршлагыг судалж үзэхэд, “Дэлхийн залуучуудын сүлжээ” анх 1998 онд байгуулагдаж, одоог хүртэл спортоор дамжуулан мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг Швед, Боливи, Норвеги, Кени, Исланд, Бермуд, Испани, Итали зэрэг улс, орнуудад амжилттай хэрэгжүүлж байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Исланд Улс 1997 оноос хойш дээрх хөтөлбөрийг 15 жилийн хугацаанд хэрэгжүүлснээр мансууруулах бодисын хэрэглээ 17.0-7.0 хувь хүртэл буурсан үзүүлэлт гарсан байна.

2.3.ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Цагдаагийн байгууллагад сүүлийн жилүүдэд бүртгэгдэн шалгагдаж байгаа гэмт хэргээс Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд заасан “Залилах” гэмт хэрэг жил дараалан өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал, энэ төрлийн гэмт хэрэг 2011 онд 688 бүртгэгдэн, шалгагдаж байсан бол 2021 онд 6679 болж 10 дахин өсч, нийт гэмт хэргийн дотор эзлэх хувь 24.5 хувь болсон байна.

Энэ төрлийн гэмт хэргээс иргэн, хуулийн этгээдийг урьдчилан сэргийлэх, санхүүгийн болон хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор зорилтот нэвтрүүлэг, видео шторк, контент, постер бэлтгэн түгээх, банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулан ажилласан байна.

Иргэд, олон нийтийн хууль, эрх зүйн болон санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр энэ оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулж 71 телевизээр мэдээлэл өгч, хэлэлцүүлэг явуулж, 25 сайтад зорилтот нийтлэл хэвлүүлж, нийт 18 постер, 12 видео шторк, 13 подкаст, лайв бэлтгэн цахим орчинд түгээлт хийсэн нь 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар нийт 4.365.847 хүнд хүрсэн байна.

“Оюутан цагдаа-2022” нэгдсэн арга хэмжээ:

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Жуулчинд ээлтэй Монгол” аяны хүрээнд гадаадын иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд оюутан залуусыг татан оролцуулах зорилгоор “Оюутан цагдаа-2022” арга хэмжээг энэ оны 06 дугаар сараас эхлэн 3 сарын хугацаатай зохион явуулсан байна.

Цагдаагийн байгууллагаас гадаадын аялагчдаас ирүүлсэн гомдол санал, дуудлага, мэдээллийг 102 тусгай дугаарт хүлээн авч холбогдох цагдаагийн газар, хэлтэст шилжүүлж, шуурхай шийдвэрлэх, жуулчид олноор явдаг маршрутыг “А”, “Б”, “В” бүс болгон ангилж, оюутан цагдаа, сонсогч нарыг өглөө, өдөр, орой 3 ээлжээр үүрэг гүйцэтгүүлж, тэдний үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна.

Улсын хэмжээнд нийт 167 сонсогч, 57 оюутан жуулчдын аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээллийг түгээн ажилласан байна.

Зам, тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Сүүлийн 10 жилийн байдлаар зам тээврийн осол, хэргийн улмаас 4593 хүний амь нас хохирч, 42489 хүн гэмтжээ. 2018-2021 оны нөхцөл байдалд харьцуулан дүн шинжилгээ хийж үзэхэд энэ оны 06-09 саруудад 250-350 орчим хүний амь нас хохирч, 700-1500 хүн гэмтэж болзошгүй нөхцөл байдал үүсээд байна. Иймд зам тээврийн осол, хэргийн улмаас иргэдийн амь нас, эд хөрөнгө хохирохоос урьдчилан сэргийлэх, хөдөлгөөнд оролцогчдын буруу дадал хандлагыг өөрчлөх, зөв үйлдэлд

уриалах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” мэдээлэл, сурталчилгаа, ухуулга нөлөөллийн ажлыг эхлүүлэн ажилласан байна.

Аяны үйл ажиллагаа нээлтээ хийсэн эхний өдөр олны танил 14 хүн лайв хийж, 28 телевиз, 31 сайт мэдээ мэдээлэл, сурвалжилга бэлтгэн, 9 постер, 5 видео шторк бэлтгэн цахим орчинд түгээлт хийсэн нь 27.569 хүнд хүрсэн байна.

Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр:

Цагдаагийн байгууллагад 2017-2021 онд нийт 148496 гэмт хэрэг бүртгэгдсэний 21369 буюу 14.4 хувь нь согтуугаар үйлдэгдсэн байх бөгөөд өдөрт 12 хэрэг, 2 цаг тутамд 1 хэрэг архидан согтуурсны улмаас үйлдэгдэж байна. Монгол Улсын Ерөнхийлөгч архи, согтууруулах ундааны хэрэглээг бууруулах талаар зарлиг гаргаж, “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөн өрнүүлж байгаатай холбогдуулан цагдаагийн байгууллага төрөөс хийж хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээг дэмжин оролцож, согтуугаар үйлдэгдэх гэмт хэргийн тоог бууруулах, архидан, согтуурахын эсрэг мэдээлэл, сурталчилгааны ажил, арга хэмжээг зохион байгуулахаар ажилласан байна.

Түүнчлэн архидан согтуурах донтой иргэдийг бие, сэтгэл заслын эмчилгээнд хамруулж, архидалтаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор үйл ажиллагаа явуулдаг сэтгэц-нийгмийн сэргээн засах “Жаргалтай амьдрал” төвийн үйл ажиллагааг өргөжүүлэн бүсчилсэн байдлаар байгуулахаар төлөвлөсөн байна.

Гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр:

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2019-2021 онд 3654 /52.0 хувь нь нийслэлд, 48.0 хувь орон нутагт/ бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 5.0 хувийг дунджаар эзэлж байгаа бөгөөд 2019 онд 8.0 хувиар буурч, 2020-2021 онд 16.0-35.0 хувь, 2022 оны эхний 5 сарын байдлаар 46.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Гэр бүлийн хүчирхийллийн хор уршгийн талаар иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээх зорилгоор “Хайр өвдгөдөггүй”, “Яг одоо”, “Би ... байна”, “Хүчирхийлэл хүн бүхэнд хамаатай”, “Харилцан хүндэтгэе” урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг улсын хэмжээнд зохион явуулж, зорилтод 48 видео, 77 мэдээ, мэдээлэл, 90 постер шинээр бүтээж, цахим сүлжээгээр иргэд, олон нийтэд түгээснийг давхардсан тоогоор 7.806.146 хүн үзэж, 177.571 хүн бусадтай хуваалцаж, 43.365 хүнд таалагдсан үнэлгээтэй байна.

Цагдаагийн байгууллагын дуудлага, мэдээллийн ECS программ хангамж болон гомдол, мэдээллийн санд 2021 онд нэмэлт хөгжүүлэлт хийн аюулын зэргийн үнэлгээг цахим хэлбэрт шилжүүлж, хэл ярианы бэрхшээлтэй иргэдээс “Мессэж”-ээр дуудлага, мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлж, интернет орчин ашиглан Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн www.e-khutuch.mn, <https://familycenter.mn/> цахим хуудасны

“Чат Пот”-оор дамжуулан гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй өргөдөл, гомдлыг хүлээн авч эхэлсэн байна.

Дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр гэр бүлийн эерэг харилцаа, хүчирхийллийн хор уршиг болон хүчирхийллийг мэдээлэхэд иргэн бүрийн үүрэг, оролцоо чухал ач холбогдолтой талаар иргэдийн ойлголт, мэдлэг нэмэгдсэн байна.

Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэрэг энэ оны 6 сарын байдлаар 600 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 383 хэргээр буюу 2.7 дахин өссөн бөгөөд нийт бүртгэгдсэн хэргийн 3.5 хувийг эзэлж байна. Мөн гэмт хэргийн улмаас 941 хүүхэд хохирсоноос 36 хүүхэд нас барж, 316 хүүхэд гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хохирсон хүүхэд 550 буюу 2.4 дахин, нас барсан хүн 10 буюу 38.4 хувь, гэмтсэн хүн 179 буюу 2.3 дахин тус тус өсчээ.

Хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэрэгцээг дэмжсэн орчин бүрдүүлэх, нийгэмд эерэг хандлага төлөвшүүлэх, нөлөөлөх зорилгоор “Цахим соёл”, “Хүүхэд хамгаалал”, “Сэрэмжлүүлье”, “Хүүхэд таныг хамгаалья” зэрэг ерөнхий арга хэмжээг зохион байгуулж, 370 төрийн болон төрийн бус байгууллага, 110 аж ахуйн нэгжтэй хамтран нийт 965 удаа 41778 иргэн, 14310 багш, нийгмийн ажилтан, 75624 сурагч, оюутнуудад сургалт зохион байгуулж, эрсдэлт нөхцөлд байгаа 3060 хүүхдэд кейс менежментийн ажиллагаа явуулж, холбон зуучлах үйлчилгээ үзүүлж, гэр бүлд нь эргэн нэгтгэх ажлыг аймаг, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулсан байна.

Цагдаагийн байгууллагаас 192 байгууллага дээр “Эцэг эхийн зөвлөл”, ерөнхий боловсролын 476 сургуульд “Өсвөрийн сэргийлэгч бүлгэм”-ийг байгуулж, 514 сургуульд “School police”, “Хүүхэд хамгаалагч”-аар 214 иргэнийг ажиллуулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна.

Өсвөр насны хүүхдэд эх оронч, зөв хүмүүжилтэй хувь хүн болгон хүмүүжүүлэх нөлөөллийн арга хэмжээний хүрээнд цагдаагийн байгууллагаас төрөн гарсан 7 генерал ерөнхий боловсролын 7 сургуулийн ахлах ангийн 390 сурагчдад “Эх орноо хайрлах, бахархах” сэдвээр, Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын удирдах 194 алба хаагч ерөнхий боловсролын 194 сургуулийн 13017 сурагчдад “Хувь хүний үнэт зүйл” сэдвээр тус тус сургалт зохион байгуулсан байна.

Цаашид цагдаагийн байгууллагаас гэмт хэргийн тоог бууруулах, иргэд, олон нийтийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөв үйлдэлд уриалах чиглэлээр мэдээлэл, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээг тасралтгүй зохион явуулахаар төлөвлөн ажилласан байна.

2.4.АЛБА ХААГЧДЫН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Алба хаагчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдаас 2022 оны эхний 5 сарын байдлаар нийт сахилгын зөрчил урд оны мөн үеэс 45.8, холбогдсон алба хаагч 46.5, удирдах албан тушаалтны сахилгын зөрчил 36.5, ажлын хариуцлага алдсан, ажил тасалсан, архидан согтуурсан, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль зөрчсөн зөрчлүүд урд оны мөн үетэй харьцуулахад 31.0-54.0, цагдаагийн алба хаагчийн сахилгын болон ёс зүйн дүрэм зөрчсөн зөрчил 34.0, иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдол 24.0 хувиар тус тус өсч, нийт сахилгын зөрчлийн 392 буюу 69.1 хувийг дотоод хяналтаар илрүүлж, хуулийн дагуу хариуцлага тооцсон байна.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, хууль хэрэглэх чадавхыг сайжруулах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу “Хүний эрх ба цагдаагийн алба хаагчийн эрх, үүрэг” сэдэвт сургалтыг энэ оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн үе шаттай зохион байгуулж, улсын хэмжээнд Цагдаа, дотоодын цэргийн нийт 36 анги, байгууллагын 3698 алба хаагчийг өнөөдрийн байдлаар хамруулан, үргэлжлүүлэн явагдсан байна.

Цагдаагийн байгууллагаас Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор алба хаагчдын авлига, хээл хахууль, хүнд суртлын талаарх мэдээллийг иргэдээс 24 цагаар хүлээн авах “126” тусгай дугаарын утсаар энэ оны эхний хагас жилийн байдлаар 301 гомдол, мэдээлэл хүлээн авч, 258-ыг шалгаж шийдвэрлэсэн байна.

Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Цагдаагийн алба хаагчид мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгох”, Засгийн газрын 2017 оны 285 дугаар тогтоолоор баталсан “Дотоодын цэргийн алба хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/88 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 77 нэгжийн 10190 алба хаагчаас мэргэжлийн зэргийн /хууль, эрх зүй болон бие бялдрын/ шалгалт авах ажлыг зохион байгуулахад цагдаагийн байгууллагаас 1106, Дотоодын цэргээс 156, нийт 1248 алба хаагч “80” “В” буюу “Сайн”, түүнээс дээш үнэлэгдэж мэргэжлийн зэргийн шалгалтад тэнцсэн байна.

Эрүүл мэнд, сэтгэл зүйн чиглэлээр:

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2021 оны А/104 дүгээр тушаалаар Аюулгүй байдлын хэлтсийн бүтцэд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагч, ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл, мэнд сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах чиг үүрэг бүхий Эрүүл мэнд, сэтгэл зүйн хэсгийг 9 орон тоотойгоор байгуулсан бөгөөд Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2022 оны А/141 дүгээр тушаалаар Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын Эрүүл мэнд, сэтгэл зүйн тасаг болгон өөрчилсөн байна.

Улсын хэмжээнд анги байгууллагуудад 54 сэтгэл зүйчийн орон тоог батлуулан үүрэг гүйцэтгэлийг хангаж ажиллаж байгаа бөгөөд “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёл, эрүүл мэнд, сэтгэл зүйг төлөвшүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулж, тус хөтөлбөрт алба хаагчдын эрүүл мэнд, сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах бодлого зохицуулалтыг хэрэгжүүлэн үүрэг гүйцэтгэлийн чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр 15 ажил, арга хэмжээг 2021-2023 онд хэрэгжүүлэхээр тусгаж, биелэлт, үр дүнг тооцон ажилласан байна.

Цагдаагийн байгууллагын Хүний нөөцийн цахим санд “Сэтгэл зүйн мэдээллийн хэсэг” цэсийг бий болгож, алба хаагчдын сэтгэл зүйн мэдээллийг цахимжуулж, сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, өөрийн сэтгэл зүйн байдлыг хянах, тулгамдсан асуудлаас урьдчилан сэргийлэх боломж бүрдсэн байна.

Цахим санд байршуулсан сэтгэл зүйн сорилоор давхардсан тоогоор 15745 алба хаагч, ажилтныг сэтгэл санааны байдлын судалгаанд хамруулахад сэтгэл гутралтай 2562, сэтгэл түгшилттэй 2458, стресстэй 2953, нойргүйдэлтэй 2562, ажлаас халшрах хам шинжтэй 2657 алба хаагч байсан бөгөөд судалгааны үр дүнгээр алба хаагч нэг бүрт сэтгэл зүйн зөвлөмжийг хүргүүлж ажилласан байна.

Монгол Улсын Боловсролын их сургуулийн “Сэтгэл зүйн үйлчилгээний төв”-ийн оюуны өмчөөр баталгаажсан “Мэргэжлийн стресс оношлох ба залруулах цогц арга зүй Идикс”-ийн арга зүйг ашиглах эрхийг худалдан авч, үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байгаа нь сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж үйлчилгээ үзүүлэх арга, ажиллагаа шуурхай явагдах нөхцөлийг анхан шатанд хүргэх зохицуулалт болсон байна.

Засгийн газрын 2017 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаагийн алба хаагчийг сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд үнэ төлбөргүй хамруулах журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор 2022 оны эхний хагас жилийн байдлаар 131 алба хаагч, ажилтныг “Сүүж-Уул” сэргээн засах сувилалд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлсэн байна.

Алба хаагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр:

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагч, ажилтнаас 2021 онд хойш албан үүргээ гүйцэтгэх явцдаа гэмт хэргийн шинжтэй 210 үйлдэлд 223 алба хаагч, зөрчлийн шинжтэй 9 үйлдэлд 9 алба хаагч, 2022 оны эхний 5 сарын байдлаар гэмт хэргийн шинжтэй 81 үйлдэлд 94 алба хаагч, зөрчлийн шинжтэй 4 үйлдэлд 4 алба хаагч тус тус өртөж, хохирчээ.

Гэмт хэргийн шинжтэй үйлдэлд өртөж хохирсон 317 алба хаагчаас 1 алба хаагч албан үүрэг гүйцэтгэлтэй холбогдолгүй нөхцөл байдлын улмаас буюу ажлын бус цагаар бусдад зодуулж, 1 алба хаагч зам тээврийн ослоор, 1 алба хаагч золгүй байдлаар, 2 алба хаагч усанд живж, 3 алба хаагч амиа хорлож тус тус амь насаа алдсан бөгөөд албан үүргээ гүйцэтгэх явцдаа халдлагад өртсөний улмаас нийт 62

алба хаагчид гэмтлийн зэрэг тогтоогдож, 248 алба хаагчид гэмтлийн зэрэг тогтоогдоогүй байна. Үүнээс байгууллагын эд хөрөнгө, алба хаагчийн хувцас, эд зүйлд хохирол учирсан 87, алба хаагчийн нэр төрд халдсан илт худал мэдээлэл тараасан 8 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

Гэмтлийн зэрэг тогтоогдсон 48 тохиолдлыг тухайн анги, байгууллагын “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс” үйлдвэрлэлийн ослын шалтгаан нөхцөлийг судлан бүртгэж, мэргэжлийн хяналтын байгууллагаар баталгаажуулахаар хүргүүлсэн ба 44 тохиолдолд ослын актыг баталгаажуулж, 4 ослын шалтгаан нөхцөлийг судлан бүртгэсэн байна.

Даатгалын байгууллагаас “Гэнэтийн ослын даатгалын гэрээ”-ний дагуу нөхөн төлбөр гаргуулахаар 44 алба хаагчийн материалыг хүргүүлснээс 28 алба хаагчид 9.753.000 /есөн сая долоон зуун тавин гурван мянга/ төгрөгийн нөхөн төлбөр олгосон бөгөөд мөрдөн шалгах ажиллагааны явцад 20 алба хаагчид учирсан 33.838.664 /гучин гурван сая найман зуун гучин найман мянга зургаан зуун жаран дөрөв/ төгрөгийн хохирлыг гэм буруутай хүнээр нөхөн төлүүлж, байгууллагын эд хөрөнгө, эд зүйлд учирсан 55.445.734 /тавин таван сая дөрвөн зуун дөчин таван мянга долоон зуун гучин дөрөв/ төгрөгийн хохирлыг тус тус барагдуулсан байна.

Мөн албан үүргээ хэрэгжүүлэх явцдаа гэмт хэрэгт холбогдсон 16 алба хаагчид холбогдох 14 хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлж, холбогдох этгээдээс цагдаагийн алба хаагчдын эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдэл гаргасан эсэхийг мөрдөн шалгах ажиллагааны явцад тал бүрээс нь бүрэн бодитой шалгах талаар үндэслэл бүхий хүсэлтийг шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газар, Мөрдөн байцаах албанд хүргүүлж, 12 алба хаагчид холбогдох 11 хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлсэн байна.

2021 онд Цагдаагийн ерөнхий газарт холбогдох эрүү, иргэн, захиргааны 57 хэргийн шүүх хуралдаанд хариуцагч, нэхэмжлэгчийн төлөөлөгчөөр 102 удаа оролцож, 41 хэргээс 39 хэрэг буюу 95.2 хувь нь байгууллагын талд шийдвэрлэгдэж, нийт 269.236.118 /хоёр зуун жаран есөн сая хоёр зуун гучин зургаан мянга нэг зуун арван найм/ төгрөгийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлсэн байна.

Энэ оны эхний 6 сарын байдлаар Цагдаагийн ерөнхий газарт холбогдох эрүү, иргэн, захиргааны 21 хэргийн шүүх хуралдаанд хариуцагч, нэхэмжлэгчийн төлөөлөгчөөр 34 удаа оролцож, 12 хэрэг буюу 100 хувь байгууллагын талд эцэслэн шийдвэрлэгдэж, нийт 353.803.806 /гурван зуун тавин гурван сая найман зуун гурван мянга найман зуун зургаа/ төгрөгийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгожээ.

Монгол Улсын Ерөнхий сайдаас олгосон итгэмжлэлийн дагуу энэ оны эхний 6 сарын байдлаар эрүүгийн хэрэгт шалгагдсаны улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэхээр иргэдээс гаргасан 362.143.662 /гурван зуун жаран хоёр сая нэг зуун

дөчин гурван мянга зургаан зуун жаран хоёр/ төгрөгийн нэхэмжлэл бүхий иргэний 3 хэрэгт оролцсоноос 334.143.662 /гурван зуун гучин дөрвөн сая нэг зуун дөчин гурван мянга зургаан зуун жаран хоёр/ төгрөгийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлсэн байна.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, алба хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, тэдэнтэй харилцан мэдээлэл солилцох, хууль зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөмж өгөх, ирүүлсэн санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах зорилгоор 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн “Алба хаагчдын чөлөөт индэр” хязгаарлалттай фэйсбүүк группийг байгуулан алба хаагчийг бүрэн нэгдүүлж, цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ, бодлого, шийдвэрийн талаар ойлголт, мэдээлэл өгөх, алба хаагч, ажилтнаас гаргасан санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэн, хуулиар хүлээсэн үүрэг гүйцэтгэлийг эрсдэлийн удирдлага, аюулгүй байдлыг үнэлэн ажилласан байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр:

Гэрч хохирогчийг хамгаалах 13 аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг зохион байгуулснаас Тодорхой үйлдлийг хязгаарлах 1, Биечилсэн хамгаалалт 7, Мэдээллийн нууцлалыг хангах 1, Сэтгэл зүйн хамгаалалт 2, Аюулгүй газарт түр байрлуулах арга хэмжээ 2, нийт 13 хамгаалалтын арга хэмжээгээр гэрч 5, хохирогч 4, хамаарал бүхий 4, нийт 13 иргэний аюулгүй байдлыг ханган ажилласан байна.

Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар Урьдчилан сануулах 128, Тодорхой үйлдлийг хязгаарлах 1, Биечилсэн хамгаалалт 2, Мэдээллийн нууцлалыг хангах 1, Нэг бүрийн болон тусгай техник хэрэгслээр хангах 1, Сэтгэл зүйн хамгаалалт 4 нийт 137 хамгаалалтын арга хэмжээгээр гэрч 4, хохирогч 125, хамаарал бүхий этгээд 4, гэмт хэргийн талаар мэдээ, мэдээлэл өгсөн 1 иргэн нийт 134 иргэний аюулгүй байдлыг хангах хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эхний хагас жилд хэрэгжүүлсэн хамгаалалтын арга хэмжээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хамгаалалтын арга хэмжээ 105 нэгжээр буюу 2.09 дахин, хамгаалуулагч 95 нэгжээр буюу 1.94 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Цалин, хөлс нэмсэн талаар:

Засгийн газрын 2014 оны “Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” 99 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаагийн алба хаагчдад мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам”-ын хэрэгжилтийг хангах чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны А/88 дугаар тушаалаар Мэргэжлийн зэргийн шалгалт авах Ажлын хэсгийг байгуулж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдаас мэргэжлийн зэргийн шалгалт авч, тэнцсэн 1248 алба хаагчид энэ оны 06 дугаар сараас эхлэн “мэргэшлийн зэргийн нэмэгдэл”-ийг сарын үндсэн цалингийн 5-25 хувиар нэмэгдүүлж олгосон байна.

Засгийн газрын 2022 оны “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн алба хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, энэ оны 05 дугаар сарын 01-ээс энгийн ажилчдын цалингийн доод хэмжээг өөрчлөн олгосон байна.

Өөрийн хаяг, байршлаа мэдэхгүй байгаа иргэнд яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын “What3words” компанитай 2021 онд “Санамж бичиг”-ийг байгуулж, “3 үгт хаяг”-ийг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн бөгөөд уг программыг ашиглан энэ онд хаяг байршлаа тодорхойлж чадахгүй 3 иргэн /ууланд төөрсөн 1, бусдын эрхшээлд автан барьцаалагдсан 2/-д яаралтай тусламж үзүүлж, авран хамгаалсан байна.

Автопарк шинэчлэх ажлын хүрээнд улсын төсвийн санхүүжилтээр 1, урсгал зардлаас 8, нийт 9 ширхэг автомашиныг 414,4 сая төгрөгөөр худалдан авч үйл ажиллагаанд ашиглаж байна. Мөн 6 иж бүрдэл мотоцикл, 7 төрлийн 17 ширхэг автомашиныг 2,1 тэрбум төгрөгөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. 2021 оноос хойш цагдаагийн байгууллагад ашиглагдаж байгаа автомашины 35 орчим хувийг шинэчилсэн байна.

2.5.НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

Нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр:

Улсын хэмжээнд авхардсан тоогоор 29788 офицер, 51628 цагдаа, нийт 81416 алба хаагч эргүүлийн үүрэг гүйцэтгэж, 79518 объект, 411209 хүн, 251375 тээврийн хэрэгсэл шалгаж, гэмт хэрэг зөрчлийн 174522 дуудлага, мэдээллийг шалгаж, 83 хэрэг, 43558 зөрчлийг илрүүлэн, 45519 иргэн, 194 хуулийн этгээд, албан тушаалтныг 1,396,359,500 төгрөгийн торгууль ноогдуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 749, түр саатуулсан тээврийн хэрэгсэл 751, 12054 хүнийг ар гэрт нь хүлээлгэн өгч, 415 хүнийг шүүхээр баривчлуулсан байна.

Эргүүл, харуулын дүрмийн 18 дугаар зүйлд зааснаар эргүүлийн нэгдсэн байршилтыг гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг эмзэг цэгийн судалгаанд үндэслэн Улсын хэмжээнд авто эргүүлийн 130 чиглэлд 260 алба хаагч, явган эргүүлийн 816 чиглэлд 1632 алба хаагч, морьт эргүүлд 236 чиглэлд 472 алба хаагч, нисдэг дронт эргүүлд 266 чиглэлд 532 алба хаагч, нийт улсын хэмжээнд 1448 чиглэлд 2896 алба хаагч ажиллахаар эргүүлийн нэгдсэн байршилтыг зохион байгуулж, хяналт тавьсан байна.

Эргүүлийн нэгдсэн байршилтыг цахимд байршуулах ажлын хүрээнд явган эргүүлийн 820, авто эргүүлийн 133, нийт 953 чиглэлийн уртраг, өргөрөгийн судалгааг улсын хэмжээнд нэгтгэн, “Arcgis” программд оруулах ажлыг Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албатай хамтран зохион байгуулж, ашиглалтад оруулсан байна.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд телехяналтын төхөөрөмжөөр тоноглогдсон нисдэг техник хэрэгслийг ашиглан эргүүл, хяналтын үйл ажиллагаанд нэвтрүүлснээр алба хаагчдыг бүтээлчээр ажиллуулах, тэдний ажлын ачааллыг бууруулах, хүний үйл ажиллагаагаар тодорхойлох боломжгүй нөхцөл байдал, эрсдлийг тогтоох, цаг хугацаа хэмнэх, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, баримтжуулах зэргээр давуу талтай байх тул эмзэг цэгийн судалгаанд үндэслэн Архангай, Баян-Өлгий, Өмнөговь, Завхан, Булган, Баянхонгор зэрэг аймгуудад үйл ажиллагаанд ашиглаж байгаа бөгөөд Баянзүрх, Сүхбаатар дүүргийн гэр хороолол, зуслангийн бүс, цэцэрлэгт хүрээлэн, голын эрэг дагуу тодорхой цагуудад нисдэг дроныг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.

Галт зэвсгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, Хууль зүйн сайдын 2015 оны А/220 дугаар тушаалаар баталсан “Галт зэвсгийн тооллого явуулах журам”-ын хэрэгжилтийг хангах, “Зэвсэг-2022” нэгдсэн арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд 2021 онд орон нутагт тооллогод хамрагдаагүй 2634 ширхэг галт зэвсгээс 1267 буюу 48.1хувь, нийслэлд 843 ширхэг галт зэвсгээс 793 буюу 94.1хувь, Улсын хэмжээнд нийт 3477 ширхэг галт зэвсгээс 2060 буюу 59.2хувь-тай нөхөн тооллогод хамрагдсан дүн мэдээг ирүүлж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгуулагуудаас ирүүлсэн санал, судалгааны дагуу 2015, 2018 оны шийдвэрээр устгалд оруулсан галт зэвсгийн шийдвэрлэлтийг оруулсан 99, санд давхар бүртгэлтэй 164 галт зэвсгийн мэдээлэлд тулгалт хийн, нийт 263 галт зэвсгийг мэдээллийн сангаас хасч, 968 галт зэвсгийн төлвийг өөрчилсөн байна.

Цагдаагийн байгууллагаас улсын хэмжээнд шүүхээс тэнсэн суллагдсан 277, хорих ялаас тэнсэн суллагдсан 182, Насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 2, жирэмсэн, 3 хүртэлх настай хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 2, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн 10, хорих ял эдлээд суллагдсан 174 нийт 647 хүнд өнөөдрийн байдлаар хяналт тогтоосон байна.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 385 дугаар тогтоолоор Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан энэ оны эхний 3 сарын хугацаанд 55 удаагийн нислэгээр 4779 иргэн хилээр нэвтэрч, УОК-оос тусгаарлан ажиглах байранд хамгаалалт авах тухай ирүүлсэн 59 албан бичгийн дагуу 28 тусгаарлан ажиглах байрны хамгаалалт, зохицуулалтад 291 алба хаагч үүрэг гүйцэтгэсэн байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 196 дугаар захирамж, Засгийн газрын 2022 оны “Замын-Үүдийн авто боомтод авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 27 дугаар тогтоолын дагуу “Эрээн-Замын-Үүд” боомтоор давхардсан тоогоор нийт 8016 тээврийн хэрэгслээр 40 тонн чингэлэг 5860 ш, 20 тонн чингэлэг 4263 ш нийт 10123 чингэлэг ачааг гаалийн хяналтын бүс рүү хүргэх, буцах үеийн хамгаалалтад давхардсан тоогоор цагдаагийн байгууллагын 2805 алба хаагч 495 тээврийн хэрэгсэлтэй хамгаалалтыг зохион байгуулсан байна.

Монгол Улсын хэмжээнд 2022 оны эхний 5 сарын байдлаар 21 аймгийн 532 дүүрэг, сумын 1136 хороо, багийн хорио цээрийн 21718 голомтод бүсэд бог мал 844967, бод мал 831911, хээргийн зэрлэг амьтан 25, мал, амьтны гоц халдвар Шүлхий, Мялзан, Ям, Боом, Галзуу, Цэцэг өвчнөөр өвчлөх үед, Хүчтэй салхи шуурга 11, Объектын гал түймэр 244, Хээрийн гал түймэр 46, Бичил уурхайн осол 4, Төөрсөн сураггүй алга болсон иргэн 12, Газар хөдлөлт 2 осол болох үеийн хэв журам сахулах хамгаалалт, зохицуулалтад давхардсан тоогоор цагдаагийн байгууллагаас 4138 алба хаагч, 1662 тээврийн хэрэгсэлтэй, бусад байгууллагын 10292 алба хаагч тус тус үүрэг гүйцэтгэсэн байна.

Төв, орон нутагт зохион байгуулагдсан 620 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтад давхардсан тоогоор 16321 алба хаагч, 2468 автомашин, 16528 тусгай хэрэгсэлтэйгээр 192,649,28 цагийн үүрэг гүйцэтгэж 257,417 орчим иргэдийн аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.

Улс төрийн нам, иргэний хөдөлгөөн, холбоо, төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн зүгээс 164 удаагийн буюу 1703 цаг үргэлжилсэн жагсаал, цуглаан, эсэргүүцлийн арга хэмжээ зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 313.659 орчим иргэн оролцох үед цагдаагийн байгууллагаас давхардсан тоогоор 2890 алба хаагч үүрэг гүйцэтгэсэн байна.

Гадаадын дипломат төлөөлөгчийн 18 газрын 21 харуулын цэг, Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурин төлөөлөгчийн газрын 1, Оюуны өмч улсын бүртгэлийн ерөнхий газрын 4, Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төвийн 1, Монгол банкны 15, нийт 41 харуулын цэгээр нэвтрэх үнэмлэхтэй 27290 иргэн, явганаар 4806, тээврийн хэрэгсэлтэйгээр 5140 иргэн, нийт 39879 удаагийн орж, гарах хөдөлгөөнд хяналт тавьж шалган нэвтрүүлэхэд зөрчил дутагдал илрээгүй байна.

Төр засгийн тэргүүнүүд төрийн ёслол хүндэтгэлийн арга хэмжээнд оролцох, нийслэл хот, төв орон нутагт товлосон объектод ирэх, буцах үеийн хамгаалалт, зохицуулалт, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр нийт 931 удаагийн хамгаалалтад давхардсан тоогоор 6548 алба хаагч, 1068 автомашинтай, 28632.6 хүн/цагийн үүрэг гүйцэтгэсэн байна.

Тайлант хугацаанд “Онцгой нөхцөл байдал үүссэн үеийн цагдаагийн байгууллагын ажиллагаа, гүйцэтгэх үүрэг, арга тактикийн чиглэлээр 30 сургагч багшийг бэлтгэж, Цагдаагийн ерөнхий газрын даргын А/88 тушаалаар “Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үеийн хүч хэрэгслийн бэлэн байдал хангах, түүнийг таслан зогсоох албадан тараах дадлага сургалт”-ыг зохион байгуулж, 4817 алба хаагчийг хамруулсан байна.

Терроризмтой тэмцэх зөвлөлтэй хамтран энэ оны 05 дугаар сард Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах томилгоот хүч хэрэгслийн бэлэн байдлыг бэлэн байдлыг хангах “Хаан шонхор 2022” нэгдсэн дадлага, сургуулилтад цагдаагийн байгууллагаас томилгоот 20 бүлгийн 860 алба хаагчийг хувийн болон албаны бэлтгэлийг хангуулж, энэ оны 05 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан байна.

Хүний эрхийн байгууллагуудтай хамтран жагсаал цуглааны үед хүний эрхийг хангах, төлөв байдлын судалгааг хийх судалгааны ажлыг Нээлттэй нийгэм форум, Хууль зүйн мэдээлэл судалгааны хамтын ажиллагааны нийгэмлэг төрийн бус байгууллагатай хамтран Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилт,

жагсаал цуглааны төлөв байдал, тулгамдсан асуудлын талаар судалгааны ажлыг энэ оны 02 дугаар сараас эхлүүлсэн байна.

Хүрээлэн буй орчны хяналтын чиглэлээр:

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд цагдаагийн байгууллагаас шалган нэвтрүүлэх цэгийн болон эргүүл хяналт, шалгалт гэсэн 2 хэлбэрээр зохион байгуулсан байна.

“Нийслэлийн хэмжээнд галлагааны үед иргэд угаарын хийн хордлогод өртөхөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх” ажлын удирдамж, “Агаарын чанарыг сайжруулах бүсэд хэрэглэгдэх түүхий нүүрс, сайжруулсан шахмал түлшний хэрэглээ, түгээлт, борлуулалтад тавих хяналт” төлөвлөгөөг Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж агаарын чанарыг сайжруулах бүсэд мэргэжлийн байгууллагуудтай хамтран “Хяналт 1”, “Хяналт 2”, “Хяналт 3” хэсэгчилсэн арга хэмжээг авсан байна.

Мөн Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 142 дугаар тушаал, Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын баталсан энэ оны “Хяналт шалгалт явуулах тухай” удирдамж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны даргын энэ оны А/01 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган, эргүүл хяналт шалгалтыг зохион байгуулсан байна.

Шалган нэвтрүүлэх цэгийн хяналтаар агаарын чанарыг сайжруулах бүсэд дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлтэй 17 аж ахуй нэгж байгууллагын 170 зууханд хэрэглэгдэх 2272 тээврийн хэрэгслээр 54049.67 тонн түүхий нүүрс, агаарын чанарыг сайжруулах бүсээр дамжин өнгөрсөн түүхий нүүрс 708 тээврийн хэрэгслээр 26953.12 тонн, баяжуулсан нүүрс 166 тээврийн хэрэгслээр 7125.85 тонн, “Таван толгой түлш” ХХК-ны түүхий эд 6300 тээврийн хэрэгслээр 252560.7 тонн татан авалтад хяналт тавьж, бүртгэл хөтөлж, дүн мэдээг нэгтгэн, зөвшөөрөлгүй түүхий нүүрс тээвэрлэсэн 5, сайжруулсан шахмал түлш тээвэрлэсэн 20 зөрчлийг илрүүлэн мэргэжлийн хяналтын байгууллагад шилжүүлэн 25 иргэнийг 2,5 сая төгрөгөөр торгох арга хэмжээ тооцуулж, 479 шуудай шахмал түлш, 95 тонн түүхий нүүрсийг хурааж, “Амгалан дулааны станц”-д төвлөрүүлэн улсын орлогод авсан байна.

ГУРАВ.ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД ХЭРЭГЖИЖ БУЙ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ

3.1.“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан арга хэмжээ

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод Цагдаагийн байгууллагад хамаарах нийт 2 зорилтын хүрээнд гүйцэтгэх 9 арга хэмжээг хяналтад авч, тэдгээрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээ авсан байна.

Хэрэгжилтийг хүснэгтээр үзүүлбэл:

№	Арга хэмжээ	Хэрэгжилт	Хувь
Зорилт 1.4. Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэл болсон нүүдлийн соёл иргэншил, Монголын түүх, хэл соёл, ёс заншил, шашин, гүн ухааны судалгаа хийж, нийтийн хүртээл болгон хэвшиж, нийгмийн соён гэгээрлийг өндөр түвшинд хүргэнэ.			

1.4.6.	Монгол хүний ёс суртахууны хэм хэмжээний талаарх судалгааг өргөжүүлэн хүүхэд залуус, төрийн албан хаагч, хууль, хүчний байгууллагын ажилтны ёс суртахууны нарийвчилсан судалгааг хийнэ.	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны сахилга, хариуцлагын зөвлөгөөнийг энэ оны 01 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулж, алба хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, сахилга, ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах зорилгоор сахилгын зөрчлийн бодит жишээн дээр тулгуурласан богино хэмжээний 42 киног бэлтгэн алба хаагчдын “Чөлөөт индэр” фэйсбүүк группэд цувралаар байршуулж, урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж байна. /Хэрэгжилт- 100хувь/	100
7.3.10.	Улаанбаатар хотод төвлөрсөн, орон нутаг дахь цагдаагийн байгууллага бүрд стандартын шаардлага хангасан эрүүлжүүлэх байрыг үе шаттайгаар барьж ашиглалтад оруулна.	Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар 37 эрүүлжүүлэх, саатуулах байр үйл ажиллагаагаа явуулж байна. /Нийслэлд 9, 21 аймагт тус бүр 1, сум дундын цагдаагийн хэлтэст 7/. Үүнээс тусдаа байртай 19, цагдаагийн газар, хэлтсийн байранд 18 /үүнээс байрны хонгилд 10/ ашиглагдаж байна. Нийт эрүүлжүүлэх, саатуулах байрны 21 буюу 56,7 хувь нь цаашид засвар хийх шаардлагатай, 4 буюу 10,8 хувь нь шинээр бариулахаар төсвийн тооцоо гаргасан, 2 буюу 5.4 хувь нь стандарт шаардлага хангасан ¹ /Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтэс, Завхан аймаг дахь цагдаагийн газрын Тосонцэнгэл сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх саатуулах байр/, мөн тайлант онд 10 буюу 27.0 хувьд нь 73.188.871 төгрөгний урсгал засвар ² хийсэн. Цагдаагийн байгууллагын эрүүлжүүлэх, саатуулах байруудын нөхцөлийг сайжруулах, нийслэлийн хэмжээнд нэгдсэн эрүүлжүүлэх, саатуулах байр барих бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий “Ажлын хэсэг”-ийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/79 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг Нийслэлийн Засаг даргын энэ оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, газрын асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийслэлийн засаг даргын тамгын газарт хүргүүлсэн. Архангай аймаг дахь цагдаагийн газрын албан контор, түр саатуулах байрны 2 блокийг 1.2 тэрбум төгрөгөөр бариулах бэлтгэл ажил бүрэн хангагдсан. /Хэрэгжилт- 100хувь/	100
7.3.12.	Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах шууд чиг үүрэг бүхий цагдаагийн алба хаагчдын ашиглах төхөөрөмжийг шинэчилж, сайжруулна.	Олон улсын Эрүүгийн цагдаагийн байгууллага-Интерполоос Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газарт 6 нэр төрлийн 53 багц хар тамхи, тэсэрч дэлбэрэх бодис тест, Бүгд Найрамдах Чех Улсын галт зэвсэг үйлдвэрлэгч “Ceska zbrojovka” байгууллага шинэ загварын 6 ширхэг галт зэвсгийг тус тус тусламжаар илрүүлснийг холбогдох баримт бичгийг	100

¹ Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх, саатуулах байр 2018 онд, Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх байр 2021 онд ашиглалтад орсон.

² Архангай, Хэнтий, Говьсүмбэр, Баян-Өлгий, Дорноговь, Дархан, Хөвсгөл, Увс аймаг дахь цагдаагийн газар, хэлтсүүд Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газрын Сайхан сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс, нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн газрын нэгдүгээр хэлтэс

		<p>бүрдүүлж, Иргэний агаарын тээвэр дэх гаалийн газраас хүлээн авч, холбогдох албан тушаалтанд тус тус хүлээлгэн өгсөн.</p> <p>Цагдаагийн байгууллагын 2022 оны урсгал зардлаас компьютер, хэвлэгч, хувилагч худалдан авахаар 1,5 тэрбум төгрөг тусгагдсан. Төсвийн хүрээнд суурин компьютер 546, зөөврийн компьютер 46, хэвлэгч 73 ширхэгийг бэлтгэж, алба, газар, хэлтсүүдэд олгосон.</p> <p>Цагдаагийн байгууллагын өөрийн бие даасан шилэн кабелийн дэд бүтцэд холбогдоогүй орон нутгийн 32, Улаанбаатар хотын 4 байгууллагын сүлжээний хурдыг нэмэгдүүлэх, тоон суваг түрээслэх аж үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах "Скайнетворк" ХХК-тай 120 сая төгрөгийн гэрээ байгуулан холболт хийгдсэн. Ингэснээр Мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдал, мэдээллийн систем, сүлжээний тасралтгүй хэвийн ажиллагааг хангасан.</p> <p>Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад 9 нэр төрлийн 117 ширхэг нэг бүрийн болон хамгаалах тухай хэрэгсэл, таблет 280, согтуурал хэмжигч багажийн нэг удаагийн хошуу, хэт богино долгионы радио станцын чихэвч 303, хэт богино долгионы дахин дамжуулах станц 2, сүлжээний 15 нэр төрлийн тоног төхөөрөмжийг худалдан авч олгосон.</p> <p>Мөн 4 нэр төрлийн 380,000 ширхэг галт хэрэглэл /сум/, нэг бүрийн тусгай хэрэгсэл буюу резинэн сумтай буу /пластик бууны гэр/ 80, резинэн сум 5000, шалгах төхөөрөмж 100, 360 гардуст бичлэг хийх зориулалттай хүзүүний камер 76 ширхэгийг тус тус худалдан авах гэрээ байгуулсан.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-</p> <p>100хувь/</p>	
<p>Зорилт 7.4. Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулан, бүтээн байгуулалтыг дэмжиж, ажиллах нөхцөлийг дээшлүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ.</p>			
7.4.4.	Салбарын алба хаагчдын цалин, хөлсний нэмэгдлийг тухайн жилийн инфляцын өсөлт, өндөр хөгжилтэй орны ижил төрлийн байгууллагын түвшинд хүргэнэ.	<p>Засгийн газрын 2014 оны "Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай" 99 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Цагдаагийн алба хаагчдад мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам"-ын хэрэгжилтийг хангах чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны А/88 дугаар тушаалаар Мэргэжлийн зэргийн шалгалт авах Ажлын хэсгийг байгуулж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдаас мэргэжлийн зэргийн шалгалт авч, тэнцсэн 1248 алба хаагчид энэ оны 06 дугаар сараас эхлэн "мэргэшлийн зэргийн нэмэгдэл"-ийг сарын үндсэн цалингийн 5-25 хувиар нэмэгдүүлж олгож байна.</p> <p>Засгийн газрын 2022 оны "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн алба хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" 107 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, энэ оны</p>	100

		05 дугаар сарын 01-ээс энгийн ажилчдын цалингийн доод хэмжээг өөрчлөн олгож байна. /Хэрэгжилт-100хувь/	
7.4.5.	Яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг хүлээн авах, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй болон бусад иргэнд үзүүлэх төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй болгож, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, эмнэлгийн түргэн тусламжийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагааны шуурхай байдлыг хангана.	<p>Өөрийн хаяг, байршлаа мэдэхгүй байгаа иргэнд яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын “What3words” компанитай 2021 онд “Санамж бичиг”-ийг байгуулж, “3 үгт хаяг”-ийг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн бөгөөд уг программыг ашиглан энэ онд хаяг байршлаа тодорхойлж чадахгүй 3 иргэн /ууланд төөрсөн 1, бусдын эрхшээлд автан барьцаалагдсан 2/-д яаралтай тусламж үзүүлж, авран хамгаалсан байна.</p> <p>Энэ оны эхний хагас жилд тусгай дугаарын утсаар гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослын 279.669, гал түймэр, гамшиг ослын 2.576, эмнэлгийн түргэн тусламжийн 169.885 дуудлага, мэдээллийг хүлээн авч, бүртгэн нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага болон гал унтраах аврах анги, түргэн тусламжийн төвд тус тус дамжуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажилласан.</p> <p>Утсаар залгаж яаралтай тусламжийн дуудлага, мэдээлэл өгөх боломжгүй нөхцөл байдалд орсон /гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, барьцаалуулсан гэх мэт гэмт/ иргэнээс дуудлага хүлээн авах боломжийг бүрдүүлэх зорилгоор яаралтай тусламжийн EIN системд өргөтгөл хийж, бүх иргэдээс богино зурвас /мессеж/-аар дуудлага мэдээлэл авах нөхцлийг бүрдүүлж 2021 онд үйл ажиллагаанд нэвтрүүлсэн бөгөөд 2021 онд 205, 2022 оны эхний 6 сарын байдлаар 137, нийт гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 342 дуудлага, мэдээллийг хүлээн авч, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад шуурхай дамжуулсан ба одоогийн байдлаар тусгай дугаарын 103, 101, 105 дугаарын утсаар иргэдээс богино зурвасаар ирүүлсэн дуудлага мэдээлэл бүртгэгдээгүй байна.</p> <p>/Хэрэгжилт-100/</p>	100
7.4.6.	Салбарын алба хаагчдын дүрэмт хувцас, зэвсэг, тусгай хэрэгсэл, тусгай зориулалтын техник хэрэгслийн чанар, стандартыг судлан тогтоож, лаборатори, үйлдвэр байгуулна.	<p>Шинжлэх ухаан технологийн их сургуулийн “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн”-тэй 2020 онд байгуулсан зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээгээр Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 155, 2019 оны 431, 2021 оны 17 дугаар тогтоолоор баталсан цагдаагийн алба хаагчийн 6 бүлгийн 68 нэр төрлийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг материалд тавигдах доорх 11 багц стандартыг боловсруулж, Стандартчилал, хэмжил зүйн газраар “Байгууллагын стандарт” болгон батлуулав.</p> <p>Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын ашиглаж байгаа сумны нөөцийг бага зардлаар бүрдүүлэх зорилгоор Америкийн нэгдсэн улсын “Mark 7R reloading” LLC байгууллагатай галт зэвсгийн хонгиог дахин цэнэглэх “Mark 7 Evolution” сум угсрагч загварын бүрэн автомат төхөөрөмж, “Hornady ammo plant”, “The evolution” загварын 11 нэр төрлийн тоног төхөөрөмжийг үндэсний аюулгүй байдлын</p>	100

		зөвлөлөөс санхүүжүүлсэн хөрөнгөөр худалдан авч, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Сум дахин цэнэглэх цехийн үйл ажиллагаа явуулах, тоног төхөөрөмж байрлуулах өрөөг тусгай зориулалтын дагуу тохижуулан засвар хийсэн. /Хэрэгжилт- 100хувь/	
7.4.7.	Салбарын автомашин, тусгай зориулалтын техник хэрэгслийн хангалтыг үе шаттайгаар шинэчилнэ.	Автопарк шинэчлэх ажлын хүрээнд улсын төсвийн санхүүжилтээр 1, урсгал зардлаас 8, нийт 9 ширхэг автомашиныг 414,4 сая төгрөгөөр худалдан авч үйл ажиллагаанд ашиглаж байна. Мөн 6 иж бүрдэл мотоцикл, 7 төрлийн 17 ширхэг автомашиныг 2,1 тэрбум төгрөгөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. 2021 оноос хойш цагдаагийн байгууллагад ашиглагдаж байгаа автомашины 40 орчим хувийг шинэчилээд байна. /Хэрэгжилт- 100хувь/	100
Дундаж			96.6

Дүгнэлт

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Цагдаагийн байгууллагад хамаарах арга хэмжээний 2022 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны 374 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу үнэлгээ хийхэд нийт 2 зорилтын хүрээнд 9 арга хэмжээ хэрэгжүүлснээс: 100 хувьтай 8, 70 хувьтай 1 нийт үнэлгээ **96.6 хувь** буюу “**Тодорхой үр дүнд хүрсэн**” гэж үнэллээ.

3.2. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Цагдаагийн байгууллагад хамаарах нийт 31 арга хэмжээг хяналтад авч, тэдгээрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээ авсан байна.

Хэрэгжилтийг хүснэгтээр үзүүлбэл:

ЗГҮАХ-т тусгагдсан, зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Зорилтот түвшин, үр дүн 2022 он		Хувь
		Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	
2.6.3. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэл-иннова-цын салбарыг хөгжүүлж, монгол	Хууль сахиулах байгууллагад соёлын өвийн эсрэг гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх нэгж байгуулж, чадавхийг бэхжүүлнэ.	Цагдаа, тагнуул, мэргэжлийн хяналт, гаалийн байгууллагад соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/315 дугаар тушаалаар Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт бүлэг, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн бүтцэд “Түүх соёлын дурсгалт зүйлийн хууль бус эргэлттэй тэмцэх тасаг”-ийг 5 орон тоотой байгуулан, цол цалингийн	100

<p>брэн-дийг бий болгож, соёл, урлагийн эдийн засаг, нийг-мийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.</p>		<p>бүтцийг бий болгон, чадавхийг бэхжүүлнэ.</p>	<p>зэрэглэлийг баталж³, алба хаагчийг томилсон. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/07 дугаар тушаалаар баталсан “Албаны болон давтан мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”-ний дагуу энэ оны 4 дүгээр сард зохион байгуулсан “Тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд анхаарах асуудал” танхим, дадлагын сургалтад тус тасгийн алба хаагчид болон нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын чиглэл хариуцсан нийт 30 алба хаагчийг хамруулсан. Мөн Соёлын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, Соёлын өвийн үндэсний төв, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран 1 эрдэм шинжилгээний хурал, 1 уулзалт зөвлөгөөн, 1 сургалт, зохион байгуулж, давхардсан тоогоор 28 алба хаагчийг хамруулсан. Алба хаагчдыг сургалт, зөвлөгөөнд хамруулснаар тэдний соёлын өвийг хамгаалах мэдлэг ойлголт, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийг нэмэгдүүлсэн ач холбогдолтой болсон.</p>	
<p>4.1.1.Төрийн байгууллагын мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйл-чилгээг шуурхай авдаг болох зо-рилтыг бүрэн хэрэгжүүлж, “Нэг иргэн-нэг бүртгэл” арга хэмжээг үргэлжлүүлэн, төрийн цахим үйл-чилгээг нэгдсэн стандартад оруулна.</p>	<p>Эрүүгийн хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа тодорхой төрлийн хэргийн материалыг цахимжуулна.</p>	<p>-</p>	<p>Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/178, А/298 дугаар тушаалаар прокурор, цагдаагийн байгууллагын хэмжээнд эрүүгийн болон зөрчлийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны цахим мэдээллийг харилцан солилцох, цахим гарын үсгээр баталгаажсан албан бичгийг үйл ажиллагаандаа ашиглах ажлыг зохион байгуулах, түүнтэй холбоотой эрх зүйн баримт бичиг боловсруулах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Цагдаа, прокурорын байгууллага хооронд цахимаар албан бичиг солилцох боломжийг бүрдүүлэх зорилгоор цагдаагийн “earchive.police.gov” програм хангамжийг прокурорын “erp” програм хангамжтай хооронд холбож, энэ оны 05 дугаар сарын</p>	<p>90</p>

³ дарга 1, чиглэлийн ахлах мөрдөгч 1, эрүүгийн ахлах мөрдөгч 1, эрүүгийн мөрдөгч 2

			27-30-ны өдрүүдэд туршилтыг амжилттай хийсэн тул мөн оны 06 дугаар сараас үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр төлөвлөсөн.	
	Хууль зүй, дотоод хэргийн салбарын цахим мэдээллийн төв байгуулна	Төвийг байгуулсан байна.	ХУД-ийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэр буюу “Буянт-Ухаа спорт цогцолбор”-ын хойд талд Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлагуудын нэгдсэн “Дата төв”, “Видео аналитик, платформ систем”, “Ханан дэлгэцийн систем”, Дата төвийн сервер, сүлжээний тоног төхөөрөмж” болон “Орон нутгийн хатуу хучилттай авто зам дагуу байрлах байнгын хяналтын 40 цэг /пост/-ийг камерын систем бүхий “Нэгдсэн удирдлага, хяналтын төв”-ийн барилгын зураг, төслийг хийхэд шаардагдах 350.0 сая төгрөгний зардлыг Барилга хот, байгуулалтын сайдын багцаас шийдвэрлүүлж, тус яамнаас зарласан тендерт тэнцсэн “Барилга байгууламж” ХХК нь барилгын зураг төслийн ажлыг хийж байгаа бөгөөд энэ оны 06 дугаар сард хүлээж авахаар төлөвлөж байна.	100
4.1.6. Үндэсний ашиг сонирхлыг хамгаалсан төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүр-тээмжтэй байдлыг хангасан мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлж, чадавхыг нэмэгдүүлнэ.	Цахим шинжилгээний лаборатори байгуулна.	Хоёрдугаар ээлжийн тоног төхөөрөмж, программ хангамж худалдан авч, кибер хадлагын ирлүүлэлт нэмэгдэнэ.	Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сан болон Америкийн Нэгдсэн Улсын Сураггүй алба болсон болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдэд туслах Олон улсын төв (ICMEC) хамтран зохион байгуулж буй Цахим орчин дахь хүүхдийн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд хэрэгжүүлж буй төслийн хүрээнд 32 мянган долларын өртөг бүхий программ хангамж, техник хэрэгслийг ⁴ 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдөр хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.	100
4.3.2. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох цогц арга	Хууль сахиулах байгууллагуудын холбоо, зэвсэглэл, техник технологийн дэвшлийг нэвтрүүлэн, дэд бүтцийг хөгжүүлнэ.	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын холбоо, зэвсэглэл, техник технологийн 50 хувийг шинэчилсэн байна.	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын холбоо, зэвсэглэл, техник технологийг шинэчлэх ажилд шаардагдах 8 тэрбум төгрөгний зардлын тооцоог ХЗДХЯ, Сангийн яаманд тус тус хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй байна. Цагдаагийн ерөнхий газрын төсвийн хөрөнгөөс 821 сая төгрөгөөр Checkpoint 6000 техник тоног төхөөрөмж /багц1/,	70

⁴ notebook 7, телевизор 1, принтер 3, тоон ул мөр илрүүлэхэд шаардлагатай 3 программ хангамж

<p>хэмжээг хэрэгжүүлснээр гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана.</p>			<p>Firewall лиценз, техник хэрэгсэл /багц2/, K2 платформ системийн лиценз /багц3/, техник хэрэгсэл, Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн 2022 оны төсвийн зардлаас 43.7 сая төгрөгөөр сервер, сүлжээ, телехяналтын камерын системийн тоног төхөөрөмжийг шинэчлэхэд шаардагдах багаж, сэлбэг хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж худалдан авч, суурилуулан, үйл ажиллагаанд нэвтрүүлэв.</p> <p>Мөн Улсын төсвийн 2022 оны урсгал зардлын 1,5 тэрбум төгрөгөөр 546 суурин компьютер, зөөврийн 46 компьютер, 73 ширхэг 3 үйлдэлтэй хэвлэгч төхөөрөмжийг худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.</p> <p>Бүгд Найрамдах Чех Улсын галт зэвсэг үйлдвэрлэгч “Ceska zbrojovka” байгууллагаас цагдаагийн байгууллагад шинэ загварын 6 ширхэг галт зэвсэг олгосныг хүлээн авсан.</p>	
	<p>Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг криминологи дүн шинжилгээ судалгаанд суурилан явуулж гадаад дотоодын байгууллагуудтай хамтран ажиллана. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт</p>	<p>Тодорхой төрлийн гэмт хэргийн криминологи судалгаа хийгдсэн байна.</p> <p>-Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт явуулна.</p>	<p>Тайлант хугацаанд гэмт хэргийн нөхцөл байдлын талаар 9, техник, технологийн талаар 3, ажлын ачааллын талаар 2, нийт 14 дүн шинжилгээ, судалгаа хийж⁵, гарсан дүгнэлт, саналыг хэрэгжүүлэх зөвлөмж, чиглэлийг холбогдох нэгжид хүргүүлсэн.</p> <p>-Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ерөнхий боловсролын 190 сургуулийн 90.137 сурагч, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн 20 төвийн 3325 оюутан нийт 93.462 сурагч, оюутан, 14310 багш ажилтан, 31200 иргэнд 1234 удаа сургалт, хэлэлцүүлэг, нөлөөллийн ажил зохион байгуулсан.</p> <p>Мөн ерөнхий боловсролын сургуулийн “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмд 422 удаа,</p>	<p>100</p>

⁵ “Залилах” гэмт хэрэг 10 жил, “Хүний амь нас хохирсон” гэмт хэрэг 3 жил, “2021 онд бүртгэгдсэн гомдол мэдээлэл, гэмт хэргийн төлөв”, “Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос үйлдэгдэж буй зам тээврийн осол, гэмт хэрэг зөрчлийн нөхцөл байдал” 1 жил, “Монгол Улсын инфляц, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал гэмт хэрэг, зөрчилд нөлөөлөх нь”, “Жагсаал, цуглааны төлөв байдал”, “Олон нийтийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй техник технологи”, “Зарим улс орны цагдаагийн байгууллагад ашиглагдаж буй дэвшилтэд шинэ техник, технологи”, “Цагдаагийн алба хаагчдын ажлын ачаалал”, “Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын эрх зүйн зохицуулалтаас үүсэх үр дагаврыг судалсан тухай, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, мөрдөгч нарын ажлын ачаалалд эрх зүйн орчны өөрчлөлт хэрхэн нөлөөлөх талаар”, “Залилах гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийг ахиулах, мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэдээллийн сан үүсгэх зорилгоор цагдаагийн байгууллагын мэдээллийн сангаас залилах гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн мэдээлэл” -д тус бүр 1 удаа дүн шинжилгээ, “Нийслэлд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал”-д 2 удаа хэсэгчилсэн судалгаа хийсэн.

	зохион байгуулах арга хэмжээ авна.		“School police” эргүүлийн үйл ажиллагаанд 3539 удаа мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.	
	Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлнэ. /Улаанбаатар хот, орон нутгийн бүх камер/	Олон улс, улсын чанартай авто замын 60 цэгт камерын хяналтын систем суурилуулж, нэгдсэн хяналтын төв байгуулсан байна.	<p>ХУД-ийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэр буюу “Буянт-Ухаа спорт цогцолбор”-ын хойд талд Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлагуудын нэгдсэн “Дата төв”, “Видео аналитик, платформ систем”, “Ханан дэлгэцийн систем”, Дата төвийн сервер, сүлжээний тоног төхөөрөмж” болон “Орон нутгийн хатуу хучилттай авто зам дагуу байрлах байнгын хяналтын 40 цэг /пост/-ийг камерын систем бүхий “Нэгдсэн удирдлага, хяналтын төв”-ийн барилгын зураг, төслийг хийхэд шаардагдах 350.0 сая төгрөгний зардлыг Барилга хот, байгуулалтын сайдын багцаас шийдвэрлүүлж, тендерт “Барилга байгууламж” ХХК шалгарч, зураг төслийн ажлыг хийж байгаа бөгөөд энэ оны 06 дугаар сард хүлээн авахаар төлөвлөж байна.</p> <p>Бүгд Найрамдах Солонгос Улсын хамтын ажиллагааны агентлаг /КОЙКА/-ын 10 сая ам.долларын буцалтгүй тусламжаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөлд дээрх нэгдсэн “Дата төв”, “Нэгдсэн удирдлага, хяналтын төв”-ийн төслийг багтаасан төслийн танилцуулгыг боловсруулж, англи хэл дээр орчуулан, 2022 оны 01/254 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн, одоогоор санхүүжилт шийдвэрлэгдээгүй байна.</p> <p>Улсын болон орон нутгийн төсвийн 448 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг, Говьсүмбэр, Дорноговь, Дархан-Уул, Сэлэнгэ, Өмнөговь, Завхан, Баянхонгор аймгийн 9 сумдын 13 постод 68 ширхэг хяналтын камерыг суурилуулж, Нийслэлийн Засаг даргын 600,0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар Энхтайваны өргөн чөлөөнд суурилуулсан чиглэлийн болон зөрчил бүртгэх хяналтын 44 камерыг шинэчилж байна.</p>	70

			2022 оны улсын төсөв болон орон нутгийн 3.8 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалтаар Баянзүрх дүүргийн 28 хорооны 160 цэгт 256 камер, Завхан, Булган, Өмнөговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Баянхонгор, Архангай, Дундговь, Сүхбаатар зэрэг 9 аймгийн 30 сумын гудамж, зам, талбайн 146 цэгт 535 ширхэг камер суурилуулахаар тоног төхөөрөмжийг худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.	
	Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох нэгдсэн санг бий болгоно.	Программ боловсруулж, туршилт эхэлсэн байна.	<p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/208 дугаар тушаалаар зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, харилцан мэдээлэл солилцох зөрчлийн бүртгэл, мэдээллийн цахим сан бий болгох ажлыг судалж, санал танилцуулах үүрэг бүхий “Ажлын хэсэг” байгуулагдсан.</p> <p>Ажлын хэсгээс “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн цахим систем хөгжүүлэх ажлын даалгавар”-г баталсан бөгөөд даалгаврын дагуу “IT zone” ХХК шалгарч, ХЗДХЯ-наас тус компанитай 2022 оны № 83393416 дугаартай ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажиллаж байна.</p> <p>Тус компаниас Bizagi Modeler программ ашиглан BPMN /Business Process Manegment Notation/ бизнес процесс зураглалын стандартыг ашиглан шүүх, прокурор, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий 32 байгууллагын дундын зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн систем, програм хангамжийг урьдчилсан байдлаар боловсруулж, ирүүлсний дагуу цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас тусгуулах саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.</p> <p>Энэ оны 09 дүгээр сард цахим системийн эхний хувилбарыг цагдаа, прокурорын байгууллагын хэмжээнд туршилтын журмаар ашиглаж, 2023 оны 01 дүгээр сараас үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр төлөвлөж байна.</p>	100
	Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчийн ажлын	Ажлын ачааллын тэнцвэржилт	Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар цагдаа, дотоодын цэргийн анги,	100

	<p>ачаал-лыг тэнцвэржүүлж үүрэг гүйцэтгэх чад-варыг нэмэгдүүлэх зорилгоор шат дараатай арга хэмжээ авна.</p>	<p>50 хувьд хүрсэн байна.</p>	<p>байгууллагад 568 орон тоо нэмэгдүүлсэнийг хуваарилан, алба хаагчийг томилсон.</p> <p>Орон тоог нэмэгдүүлсэнээр нэг алба хаагчид оногдох ачаалал буурахад эерэг нөлөө үзүүлэх боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Мөн цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас орон тоо шилжүүлэх, албан тушаалын нэршил өөрчлөх, цол, цалингийн зэрэглэл нэмэгдүүлэх, харьяалал өөрчлөх саналтай ирүүлсэн материалын дагуу холбогдох судалгааг хийж, 34 тушаалаар 34 бүтцэд өөрчлөлт оруулж, шинээр байгуулагдсан орон тоонд алба хаагчдыг томилж, нэг алба хаагчид оногдох ажлын ачааллыг бууруулах чиглэлээр анхаарч ажиллаж байна.</p> <p>Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын ажлын байрны нөхцөл, ажлын үнэлэмж, ажилдаа хандах хандлага, ажлын ачаалал, хүндрэл бэрхшээл, үүсгэж буй хүчин зүйлсийг мэргэжлийн судалгааны байгууллагаар тогтоолгох зорилгоор 3 үе шаттай “Цагдаагийн алба хаагчдын ажлын ачаалал, ажиллах нөхцөл боломж, ажил мэргэжилдээ хандах хандлага” судалгааны ажлыг “Максима” ХХК-иар гүйцэтгүүлж, ирүүлсэн тайлан зөвлөмжийн дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/142 дугаар тушаалаар цагдаагийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгох, цагдаагийн алба хаагчдын ажиллах нөхцөл боломж, ажил мэргэжилдээ хандах хандлагыг дээшлүүлэх зорилгоор хийж хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг тодорхойлох үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан.</p> <p>Ажлын хэсгээс бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, ажлын ачааллыг тэнцвэржүүлж, бууруулах нөхцөл боломжийг судалж, цаашид авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний саналыг бэлтгэж байна.</p>	
	<p>Улаанбаатар хотод төвлөрсөн, орон нутаг дахь эрүүлжүүлэх, цагдан хорих,</p>	<p>нийт ажлын 50 хувийг хийж гүйцэтгэнэ.</p>	<p>Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар 37 эрүүлжүүлэх, саатуулах байр үйл ажиллагаагаа явуулж байна. /Нийслэлд 9, 21 аймагт тус бүр 1,</p>	<p>70</p>

	баривчлах байр, албаны байрны нөхцөлийг стандартад нийцүүлнэ		<p>сум дундын цагдаагийн хэлтэст 7/. Үүнээс тусдаа байртай 19, цагдаагийн газар, хэлтсийн байранд 18 /үүнээс байрны хонгилд 10/ ашиглагдаж байна.</p> <p>Нийт эрүүлжүүлэх, саатуулах байрны 21 буюу 56,7 хувь нь цаашид засвар хийх шаардлагатай, 4 буюу 10,8 хувь нь шинээр бариулахаар төсвийн тооцоо гаргасан, 2 буюу 5.4 хувь нь стандарт шаардлага хангасан⁶ /Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтэс, Завхан аймаг дахь цагдаагийн газрын Тосонцэнгэл сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх саатуулах байр/, мөн тайлант онд 10 буюу 27.0 хувьд нь урсгал засвар⁷ хийсэн.</p> <p>Цагдаагийн байгууллагын эрүүлжүүлэх, саатуулах байруудын нөхцөлийг сайжруулах, нийслэлийн хэмжээнд нэгдсэн эрүүлжүүлэх, саатуулах байр барих бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий “Ажлын хэсэг”-ийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/79 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг Нийслэлийн Засаг даргын энэ оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, газрын асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийслэлийн засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.</p> <p>Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабарын дагуу 2023 оны төсвийн хязгаарын санал, төсвийн төсөлд тусгуулахаар Булган, Говьсүмбэр, Өвөрхангай, Хэнтий аймаг дахь цагдаагийн газарт шинээр эрүүлжүүлэх, саатуулах байр барих саналыг энэ оны 01/267 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Архангай аймаг дахь цагдаагийн газрын албан контор, түр саатуулах байрны 2 блокийг 1.3 тэрбум төгрөгөөр бариулах бэлтгэл ажил бүрэн хангагдсан.</p>	
--	--	--	---	--

⁶ Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх, саатуулах байр 2018 онд, Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх байр 2021 онд ашиглалтад орсон.

⁷ Архангай, Хэнтий, Булган, Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн газар

<p>4.3.3. Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байрыг байгуулж, хуульд заасны дагуу мэдээллээр хангана.</p>	<p>Гэрч хохирогчийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.</p>	<p>Өмнөх оны судалгааны дүнг харьцуулан өсөлт бууралт, үр дүнг тооцно.</p>	<p>Хөтөлбөрийн хүрээнд цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2022 онд хэрэгжүүлэх ажлын 44 заалт бүхий төлөвлөгөө батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд энэ оны эхний хагас жилийн хэрэгжилтийг нэгтгэж байна.</p> <p>Тайлант хугацаанд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан урьдчилсан сануулах 180, тодорхой үйлдлийг хязгаарлах 1, биечилсэн хамгаалалт 8, мэдээллийн нууцлалыг хангах 2, нэг бүрийн тусгай техник хэрэгслээр хангах 1, аюулгүй газарт түр байрлуулах 3, сэтгэл зүйн хамгаалалт 6, нийт 201 хамгаалалтын арга хэмжээгээр гэрч 8, хохирогч 183, гэмт хэргийн талаар мэдээлэл өгсөн, туслалцаа үзүүлсэн 1 иргэн, хамаарал бүхий 4 иргэн, нийт 196 хамгаалуулагч иргэний аюулгүй байдлыг хангаж ажилласан.</p> <p>Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт хамгаалалтын арга хэмжээ 105 нэгжээр буюу 2.09 дахин, нийт хамгаалуулагч 95 нэгжээр буюу 1.94 дахин өссөн үзүүлэлттэй байна.</p>	<p>100</p>
	<p>Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, тусгай хэрэгцээт (хөгжлийн бэрхшээлтэй) иргэдийг хамгаалах төрөлжсөн түр хамгаалах байр байгуулна.</p>	<p>Түр хамгаалах байраар үйлчлүүлсэн иргэдийн тоо өссөн буурсан шалтгааныг өмнөх жилүүдтэй харьцуулсан байдлаар үр дүнг тооцно.</p>	<p>Улсын хэмжээнд 36 түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв үйл ажиллагаа явуулж байгаа ба тайлант хугацаанд нийт 1853 иргэн /Үүнээс насанд хүрсэн эрэгтэй 20, эмэгтэй 576, хүүхэд 1257/ үйлчлүүлсэн.</p> <p>Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс нийт үйлчлүүлсэн иргэн 372-оор буурсан /Үүнд эрэгтэй 61 буюу 75.3 хувиар, эмэгтэй 115 буюу 16.6 хувиар, хүүхэд 196 буюу 13.5 хувиар буурсан/ байна.</p>	<p>100</p>
<p>4.3.4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.</p>	<p>Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, төрийн болон төрийн бус, ОУ-ын байгууллагын хамтын ажил-</p>	<p>Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангаж ажиллана.</p>	<p>Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны 2022 оны ээлжит хуралдаанаар хэлэлцэн баталсан “Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхээр цагдаагийн байгууллагаас хийж гүйцэтгэх ажлын 14 заалт бүхий</p>	<p>100</p>

	лагааг сайжруулна.		төлөвлөгөө гарган ажиллаж байна.	
	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчилд холбогдох, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн улмаас хохирох эрсдэлтэй зорилтот бүлгийг тодорхой-лоход чиглэсэн судалгаа, тандалтын ажлыг зохион байгуулж, судалгаанд суурилсан УС бодлого боловс-руулж хэрэгжүүлэн ажиллана.	Судалгаанд суурилсан стандарттай болсон байна.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдох эрсдэлтэй 13-25 насны зорилтот бүлгийн хүүхэд, залуучуудын дунд 6 модуль, 10,000 респондент бүхий тандалт судалгааны ажлыг “Максима” ХХК-иар 2020-2021 онд гүйцэтгүүлж дүгнэлт, зөвлөмжийг энэ оны 05 дугаар сарын 08-ны өдөр хүлээн авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглахтай холбоотой гэмт хэрэгт шүүхээр ял шийтгэгдсэн иргэдийн судалгааг 2012 оны 01 дүгээр сарын 01-нээс 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийг хүртэлх хугацааны байдлаар гаргаж, дүн шинжилгээний ажилд ашиглаж байна. Дээрх судалгааны дүнг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс Хууль зүй, дотоод хэргийн сайд, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хороонд танилцуулж, гаргасан шийдвэрийн дагуу судалгаанд суурилсан стандартыг боловсруулах ажлыг эхлүүлэхээр чиглэл ирүүлсэн.	100
	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой тэмцэх ажлыг эрчимжүүлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, хувцас хэрэглэлийг шинэчлэх, мансууруулах, сэтгэцэд нөлөөт ургамлын тархац бүхий нутаг дэвсгэрт устгалын арга хэмжээг өргөн цар хүрээтэй зохион байгуулах, алба хаагчид, мэргэжилтнүүдийг мэргэшүүлнэ.	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт ургамлын тархац хязгаарлаж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажилд ахиц гарсан байна	Мансууруулах үйлчилгээтэй зэрлэг олсны ургамал /каннабис/-ын тархац тогтоогдсон 11 аймгийн нутаг дэвсгэрийн 1800 га талбайд энэ оны 6 дугаар сарын 10-аас 07 дугаар сарын 08-ны өдрийг хүртэл “Устгал” арга хэмжээг явуулж байна. Устгал хийхэд шаардагдах 61 сая төгрөгийн санхүүжилтийг 2022 оны улсын төсөвт тусгуулж батлуулсан.	100
	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт	Сургалтын нэгдсэн	-Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт	100

	<p>бодисоос урьдчилан сэргийлэх сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулж, хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулна.</p>	<p>хөтөлбөрийн дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд сургагч багш бэлтгэж, албан бус сургалтын хэлбэрээр сургалт зохион байгуулснаар Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус хэрэглээтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн тоо буурна.</p>	<p>хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, өсвөр насны хүүхэд залуучуудыг хорт зуршлаас ангид байлгах, хараа хяналтыг сайжруулах чиглэлээр тэдний эцэг, эх, багш, нийгмийн ажилтнуудад чиглэсэн сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулах “Сургагч багш” бэлтгэх сургалтыг 2022 оны 03 дугаар сарын 10-наас 11-ний өдрийн хооронд зохион байгуулж, 31 алба хаагчийг хамруулан гэрчилгээ олгосон.</p> <p>Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисоос Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисоос урьдчилан сэргийлэх чиглэлээр “Оюутан сурагчдад зориулсан сургалт мэдээллийн хөтөлбөр”, “Эцэг эх, асран хамгаалагч, багш нийгмийн ажилтанд зориулсан сургалтын, мэдээллийн хөтөлбөр”-ийг энэ оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Хар тамхитай тэмцэх газрын дарга баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Энэ оны эхний хагас жилд 57 төрийн байгууллагын 2772 алба хаагч, 30 төрийн бус байгууллагын 3998 ажилтан, 16 их, дээд сургуулийн 317 багш, 2635 оюутан, ерөнхий боловсролын 57 сургуулийн 1250 багш, нийгмийн ажилтан, ахлах ангийн сурагчдын 5230 эцэг, эх асран хамгаалагч, нийт 16202 хүнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, хэрэглэсэн хүнд илрэх шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулж, 16000 ширхэг гарын авлага тараан тэдний мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний хор уршиг, үр дагаврын тухай ойлголт мэдлэгийг нэмэгдүүлсэн.</p> <p>- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, эрэлт нийлүүлэлтийг хязгаарлах, борлуулалт нийлүүлэлтийн сүлжээг таслан зогсоох, сэжигтэй этгээд бүлэг бөөгнөрөл, тэдгээрийн хууль бус үйлдлийг илрүүлэх, эмзэг цэгүүдэд чиглэсэн удаа дараагийн арга хэмжээг үе шаттай зохион явуулсны үр дүнд энэ оны эхний</p>
--	---	--	--

			хагас жилийн байдлаар 78 гэмт хэрэгт 78 сэжигтэн бүртгэгдэж, эд мөрийн баримтаар 8765 хүн/тун хэмжээ бодисыг хурааж авсан нь суурь он болох 2019 оны мөн үетэй харьцуулахад гэмт хэрэг 42 нэгжээр буюу 53 хувиар буурсан байна. ⁸	
4.3.5. Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ.	Хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх арга хэмжээг төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ.	Төлөвлөгөө батлагдахаас өмнөх оны байдлыг төлөвлөгөө батлагдсанаас хойшхи хэрэгжилттэй харьцуулан үр дүнг тооцно.	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 /Хүн худалдаалах/, 12.6 /Биеэ үнэлэхийг зохион байгуулах/ дугаар зүйлд заасан гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө, иргэд, олон нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор 4 бүлэг, 15 заалт бүхий төлөвлөгөө батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр нэгдсэн ⁹ арга хэмжээ 2, хэсэгчилсэн арга хэмжээ 3, нэгдсэн үзлэг шалгалтыг 8 удаа зохион байгуулж биелэлт, үр дүнг тооцсон.	100
	Эмэгтэйчүүдийг бэлгийн дарамтад өртөж, хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	Хөшигийн хөндийн шинэ нисэх буудалд системийг бүрэн нэвтрүүлж, мэдээллийн төвийн үйл ажиллагааг эхлүүлж, орон тоог нэмэгдүүлсэн байна.	Засгийн газрын 2021 оны өдрийн 261 дүгээр тогтоолоор НҮБ-ын Терроризмтой тэмцэх албанаас хэрэгжүүлж буй зорчигчийн урьдчилсан мэдээллийн дэвшилтэд систем "goTravel" буюу "API/PNR"-ийн үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлэх ажлын хүрээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагаар Хил хамгаалах ерөнхий газрыг тогтоож, хөтөлбөрийн үндэсний зохицуулагчийн чиг үүргийг Терроризмтой тэмцэх зөвлөлийн Ажлын албанд хариуцуулсан. Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтсээс Хөшгийн хөндийн шинэ нисэх буудалд иргэний нисэхийн хориотой, хамгаалагдсан болон нийтийн эзэмшлийн бүсэд мөрдөгдөх хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, уг бүсэд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл	100

⁸ Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн нэгдсэн сан.

⁹ Хүүхэд хамгаалал, Сэрэмжлье,

			ажиллагаа явуулах, Иргэний нисэхийн байгууллагатай хамтран ажиллах, тэдэнд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	
4.3.10. Ачаа болон нийтийн зорчигч тээвэрлэлтийн зориу-лалттай тээврийн хэрэгсэл автомашины камертай байх стан-дартыг тогтоож, ба-руун гар талдаа жо-лооны хүрдтэй тээв-рийн хэрэгслийн им-портыг үе шаттайгаар хязгаарлах, зам тээв-рийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөө-тэй бодлогыг хэрэг-жүүлэх замаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, зам тээврийн осол, түүнээс үүдэх хор уршгийг бууруулна	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай, Автозамын тухай, Зөрчлийн тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна.	Замын хөдөлгөөний аюулгүй байдал хангагдах, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчил болон замын тээврийн осол, түүнээс үүсэх хор уршиг тодорхой хэмжээгээр буурсан байна.	Энэ оны эхний 5 сарын байдлаар автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 486 бүртгэгдэж, осол, хэргийн улмаас 106 хүний амь нас хохирч, 412 хүн гэмтсэнийг суурь он болох 2019 оны мөн үетэй харьцуулахад гэмт хэрэг 15.6 хувиар, ослын улмаас амь нас нь хохирсон хүн 18.5 хувиар, гэмтсэн хүн 9.0 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн улмаас иргэд, аж ахуй нэгж байгууллагад учирсан 3.021.250.748 төгрөгийн хохирол учирсны 76.6 хувь буюу 2.314.092.900 төгрөгийг нөхөн төлүүлсэн байна.	100
4.3.18. Архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчим-жүүлж архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчил-гээний үндэсний чадавхыг бэхжүүл-нэ. Архидан согтуурахтай тэмцэх сангийн үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээг авна.	Согтууруулах ундааны эргэлт болон хэрэглээ, архидан согтуурал-таас үүдэлтэй сөрөг үр дагаврыг бууруу-лах зорилгоор Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи-дан согтуурахтай тэмцэх тухай хуу-лийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, УИХ өргөн мэдүүлнэ.	Хуулийн төслийг боловсруулсан байна.	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Засгийн газраас 2021 оны 03 дугаар сарын 19-нд УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Хууль зүйн байнгын хорооны ажлын дэд хэсгийн хуралдаан 2021 оны 12 дугаар сарын 07-нд болсон.	100
4.4.7. Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг,	Зарим төрлийн гэмт хэрэг, тухайлбал, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	-	Эрүүгийн хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, боловсронгуй болгох чиг үүрэг бүхий Байнгын ажлын хэсэгт цагдаагийн байгууллагыг төлөөлөн ажиллах алба хаагч нарын нэрсийг 2022 оны 01/134	100

<p>зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно.</p>	<p>үйлдсэн этгээдэд оногдуулах ялыг чангатгана.</p>		<p>дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Эрүүгийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлсон мэдээлэл, саналыг 2022 оны 2/22 дугаар албан бичгээр Улсын Ерөнхий Прокурорын газарт хүргүүлсэн.</p>	
<p>4.4.7. Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно.</p>	<p>Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар зохицуулах харилцааг зааглан оновчтой тогтоож, зөрчилд оногдуулах торгох шийтгэлийн хэмжээг уян хатан зохицуулах зорилгоор Зөрчлийн тухай хуулийг шинэчлэн боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлнэ.</p>	-	<p>Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн. Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Хууль зүй, дотоод хэргийн яамны Ажлын хэсэгт цагдаагийн байгууллагыг төлөөлөн 3 алба хаагч ажиллаж байна.</p>	100
<p>зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно.</p>	<p>Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай, авлига, албан тушаалын болон шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх мөрдөн шалгах чиг үүрэг бүхий Мөрдөх албаны тогтолцоог боловсронгуй болгох хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлнэ.</p>	<p>Хуулийн төслийг боловсруулсан байна.</p>	<p>Шинэ төрлийн зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий бие даасан бүтэц бүхий мөрдөх албыг байгуулах, тогтолцоо, чиг үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, хяналт тавих, алба хаагчдын эрх зүйн байдлыг тодорхойлох зохицуулалт бүхий Мөрдөх албаны тухай хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсэгт ажиллах алба хаагчийн нэрийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас шаардагдах мэдээллийг бэлтгэж байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Эрүүгийн хуулийн 14.5-14.9 дүгээр зүйлд</p>	100

			заасан гэмт хэрэгт тагнуулын байгууллага мөрдөн шалгах ажиллагааг явуулах саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.	
	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, ял хариуцлагыг нэмэг-дүүлэх, мансуурах донтой этгээдэд эрүүл мэндийн тусламж үзүүлэх, эрт шатанд нь илрүүлэх, эмчлэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор холбогдох хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлнэ.	Хуулийн төслийг боловсруулсан байна.	Хууль зүйн сайдын 2020 оны А/156 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсгээс “Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, мансуурахтай тэмцэх тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулж Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон. Цагдаагийн байгууллагаас уг хуулийн төсөлд нэмж тусгуулах саналыг Ажлын хэсэгт 3 удаа хүргүүлсэн.	100
4.4.8. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, мал хулгайлах гэмт хэргийг бууруулна.	Малыг нэгдсэн бүрт-гэлд бүртгэх, ялган тэмдэглэх хэрэгсэлтэй болгох, мал, малын гаралтай бүтээгдэхүүний худалдааны эргэлтэд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Мал хулгай-лах гэмт хэрэгтэй тэм-цэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруул-гын төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлнэ.	Хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/30 дугаар тушаалаар баталсан “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий “Ажлын хэсэгт” цагдаагийн байгууллагыг төлөөлөн 2 алба хаагч ажиллаж, санал дүгнэлт боловсруулж байна. Дээрх хуульд малыг нэгдсэн бүртгэлд бүртгэх, ялган тэмдэглэх хэрэгсэлтэй болгох, мал, малын гаралтай бүтээгдэхүүний худалдааны эргэлтэд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх талаар тусгуулах саналыг боловсруулж, Ажлын хэсэгт танилцуулахаар бэлтгэж байна.	100
4.4.12. Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандла-гыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрүү шүүлтээс	Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлийг тас-лан зогсоох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрүү шүүлтээс	Эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.	Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр 1 хууль, 4 журмын төсөлд тусгуулах саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн: Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцын талаар мөрдөн шалгах байгууллагын	100

урьдчилан сэргийлэх ажлыг үр дүн-тэй хэрэгжүүлнэ.	урьдчилан сэргийлэх ажлыг үр дүн-тэй хэрэгжүүлнэ		удирдлагын зөвшөөрлөөр олон нийтэд мэдээлэл өгөх зохицуулалтын талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах саналыг 2022 оны 5/31, Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар батлах “Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл журам”-ын төсөлд тусгуулах саналыг энэ оны 01/137, 2017 оны А/70, А/174 дүгээр тушаалаар баталсан “Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журам” болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/142 дугаартай тушаалаар баталсан “Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журам”-д өөрчлөлт оруулах саналыг 2022 оны 3/97 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.	
Нийт дундаж				96.6

Дүгнэлт

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Цагдаагийн байгууллагад хамаарах арга хэмжээний 2022 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны 374 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу үнэлгээ хийхэд нийт 2 зорилтын хүрээнд 9 арга хэмжээ хэрэгжүүлснээс: 100хувь-тай 8, 70хувь-тай 1 нийт үнэлгээ 96.6хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэллээ.

ДӨРӨВ.ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ТАЛААР

Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэг гэдэгт гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажил багтах бөгөөд энэ хэсэгт цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэг, түүнийг тодорхойлох 8 асуултыг судалгаанд оролцогчдод тавьж, асуулт тус бүрээр дүн шинжилгээ хийсэн болно.

4.1.Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаар сэтгэл ханамжийн үнэлгээ

Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаар 480 иргэн судалгаанд хамрагдсан ба асуулгад хариулсан хариултын сонголтыг 1-5 хүртэлх тоон үнэлгээгээр үнэлж судалгааг авсан.

Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, тоо, хувиар

Хүснэгт №3

Асуултууд	Дундаж	Огт санал нийлэхгүй		Санал нийлэхгүй		Дунд зэрэг		Санал нийлнэ		Бүрэн санал нийлнэ	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Цагдаагийн байгууллагад гэмт хэргийн дуудлага тохиолдолд хугацаанд ирдэг	4.2	50	10.4	54	11.3	180	37.5	121	25.2	75	15.6
Гэмт хэрэг талаар цагдаагийн байгууллагад мэдээлсэн тохиолдолд гэмт этгээдийг олж баривчилдаг	2.7	74	15.4	89	18.5	147	30.6	100	20.8	70	14.5
Ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цагдаагийн байгууллага түргэн шуурхай илрүүлдэг	3.6	58	12.1	60	12.5	76	15.8	197	41.0	89	18.5
Цагдаагийн алба хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хангалттай зохион байгуулдаг	3.7	44	9.2	70	14.6	89	18.5	181	37.7	96	20.0

Тайлбар: Огт санал нийлэхгүй – 1, Санал нийлэхгүй – 2, Дунд зэрэг – 3, Санал нийлнэ – 4, Бүрэн санал нийлнэ - 5

Эх үүсвэр: Судлаачийн SPSS 21 програмаар тооцсон дүн

Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн үнэлгээ, тоо, хувиар, үргэлжлэл

Хүснэгт №4

Асуултууд	Дундаж	Огт санал нийлэхгүй		Санал нийлэхгүй		Дунд зэрэг		Санал нийлнэ		Бүрэн санал нийлнэ	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Орон нутгийн хэмжээнд гэмт хэргийг таслан зогсоох ажиллагааг цагдаагийн байгууллага үр дүнтэй хэрэгжүүлдэг	4.16	50	10.4	48	10.0	213	44.4	104	21.7	65	13.5
Цагдаагийн алба хаагч хэв журам сахиулах үүргийг тухайн нутаг дэвсгэрт маш сайн гүйцэтгэдэг	4.16	49	10.2	49	10.2	105	21.9	178	37.1	99	20.6
Цагдаа орон нутгийн хэмжээнд зохион байгуулдаг олон нийтийг хамарсан спорт, урлаг, баяр наадам, жагсаал цуглааныг зохицуулах,	4.16	30	6.3	50	10.4	171	35.6	103	21.5	126	26.3

аюулгүй байдлыг хангах үүргээ сайн гүйцэтгэдэг											
Цагдаагийн алба хаагч замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлдэг	4.16	40	8.3	46	9.6	165	34.4	99	20.6	130	27.1
Ерөнхий дундаж	4.16	169	8.8	193	10.1	654	34.1	484	25.2	420	21.9

Тайлбар: Огт санал нийлэхгүй – 1, Санал нийлэхгүй – 2, Дунд зэрэг – 3, Санал нийлнэ – 4, Бүрэн санал нийлнэ - 5

Эх үүсвэр: Судлаачийн SPSS 21 програмаар тооцсон дүн

Дээрх хүснэгтээс харахад судалгаанд оролцогсдын **“Цагдаагийн байгууллагад гэмт хэргийн талаар дуудлага өгсөн тохиолдолд богино хугацаанд хүрэлцэн ирдэг”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 4.2 буюу санал нийлдэг гэж хариулсан бол нийт судалгаанд оролцогчдын 50 иргэн буюу 10.4 хувь нь огт санал нийлэхгүй, 54 иргэн буюу 11.3 хувь нь санал нийлэхгүй, 180 иргэн буюу 37.5 хувь нь дунд зэргийн санал нийлнэ, 121 иргэн буюу 25.2 нь санал нийлнэ, 75 иргэн буюу 15.6 хувь нь бүрэн санал нийлнэ гэж хариулт өгсөн байна.

“Гэмт хэрэг үйлдэгдсэн талаар цагдаагийн байгууллагад мэдээлсэн тохиолдолд гэмт этгээдийг заавал олж баривчилдаг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 2,7 буюу дунд зэрэг санал нийлдэг гэж хариулсан бол нийт судалгаанд оролцогчдын 74 иргэн буюу 15.4 хувь нь огт санал нийлэхгүй, 89 иргэн буюу 18.5 хувь нь санал нийлэхгүй, 147 иргэн буюу 30,6хувь нь дунд зэргийн санал нийлнэ, 100 иргэн буюу 20.8 хувь нь санал нийлнэ, 70 иргэн буюу 14.5 хувь нь бүрэн санал нийлнэ гэж хариулт өгсөн байна.

“Ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цагдаагийн байгууллага түргэн шуурхай илрүүлдэг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.6 буюу санал нийлдэг гэж хариулсан бол нийт судалгаанд оролцогчдын 58 иргэн буюу 12.1 хувь нь огт санал нийлэхгүй, 60 иргэн буюу 12.5 хувь нь санал нийлэхгүй, 76 иргэн буюу 15.8 хувь нь дунд зэргийн санал нийлнэ, 197 иргэн буюу 41.0 хувь нь санал нийлнэ, 89 иргэн буюу 18.5 хувь нь бүрэн санал нийлнэ гэж хариулт өгсөн байна.

“Цагдаагийн алба хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хангалттай зохион байгуулдаг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.7 буюу санал нийлдэг гэж хариулсан бол нийт судалгаанд оролцогчдын 44 иргэн буюу 9.2 хувь нь огт санал нийлэхгүй, 70 иргэн буюу 14.6 хувь нь санал нийлэхгүй, 89 иргэн буюу 18.5 хувь нь дунд зэргийн санал нийлнэ, 181 иргэн буюу 37.7 хувь нь санал нийлнэ, 96 иргэн буюу 20.0 хувь нь бүрэн санал нийлнэ гэж хариулт өгсөн байна.

“Орон нутгийн хэмжээнд гэмт хэргийг таслан зогсоох ажиллагааг цагдаагийн байгууллага үр дүнтэй хэрэгжүүлдэг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 4.1 буюу санал нийлдэг гэж хариулсан бол нийт судалгаанд оролцогчдын 50 иргэн буюу 10.4 хувь нь огт санал нийлэхгүй, 48 иргэн

буюу 10.0 хувь нь санал нийлэхгүй, 213 иргэн буюу 44.4 хувь нь дунд зэргийн санал нийлнэ, 104 иргэн буюу 2.7 хувь нь санал нийлнэ, 65 иргэн буюу 13.5 хувь нь бүрэн санал нийлнэ гэж хариулт өгсөн байна.

“Цагдаагийн алба хаагч хэв журам сахиулах зорилгоор манай нутаг дэвсгэрт эргүүлийн үүрэг маш сайн гүйцэтгэдэг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 4,1 санал нийлдэг гэж хариулсан бол нийт судалгаанд оролцогчдын 49 иргэн буюу 10.2 хувь нь огт санал нийлэхгүй, 48 иргэн буюу 10.2 хувь нь санал нийлэхгүй, 105 иргэн буюу 21.9 хувь нь дунд зэргийн санал нийлнэ, 178 иргэн буюу 37.1 хувь нь санал нийлнэ, 99 иргэн буюу 20.6 хувь нь бүрэн санал нийлнэ гэж хариулт өгсөн байна.

“Цагдаа орон нутгийн хэмжээнд зохион байгуулдаг олон нийтийг хамарсан спорт, урлаг, баяр наадам, жагсаал цуглааныг зохицуулах, аюулгүй байдлыг хангах үүргээ сайн гүйцэтгэдэг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 4.16 буюу санал нийлдэг гэж хариулсан бол нийт судалгаанд оролцогчдын 30 иргэн буюу 6.3 хувь нь огт санал нийлэхгүй, 50 иргэн буюу 10.4 хувь нь санал нийлэхгүй, 171 иргэн буюу 35.6 хувь нь дунд зэргийн санал нийлнэ, 103 иргэн буюу 21.5 хувь нь санал нийлнэ, 126 иргэн буюу 26.3 хувь нь бүрэн санал нийлнэ гэж хариулт өгсөн байна.

“Цагдаагийн алба хаагч замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлдэг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 4.1 буюу санал нийлдэг гэж хариулсан бол нийт судалгаанд оролцогчдын 40 иргэн буюу 8.3 хувь нь огт санал нийлэхгүй, 46 иргэн буюу 9.6 хувь нь санал нийлэхгүй, 165 иргэн буюу 34.4 хувь нь дунд зэргийн санал нийлнэ, 99 иргэн буюу 20.6 хувь нь санал нийлнэ, 130 иргэн буюу 27.1 хувь нь бүрэн санал нийлнэ гэж хариулт өгсөн байна.

Нийт судалгаанд оролцогчдын хариулсан байдлаас харахад **90.1 хувь** нь дээрх асуусан нөхцөлд санал нийлнэ гэж хариулсан байна.

ТАВ.ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДЫН ХАРИЛЦААНЫ СОЁЛ, ЁС ЗҮЙН ТӨЛӨВШИЛ

Доорх асуултууд нь таны оршин сууж буй нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын алба хаагчдын ёс зүй, харилцааны соёлыг тодорхойлоход чиглэгдэнэ.

5.1.Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшилтийн талаарх сэтгэл ханамжийн үнэлгээ

Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаар 480 иргэн судалгаанд хамрагдсан. Асуултанд хариулсан хариултын сонголтыг 1-5 хүртэлх тоон үнэлгээгээр үнэлж судалгааг авсан.

Цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн

төлөвшилтийн үнэлгээ, тоо, хувиар

Хүснэгт №5

Асуултууд	Дундаж	Огт санал нийлэхгүй		Санал нийлэхгүй		Дунд зэрэг		Санал нийлнэ		Бүрэн санал нийлнэ	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг	4.0	55	11.5	81	16.9	136	28.3	100	20.8	108	22.5
Цагдаагийн алба хаагчаас мэдээлэл авах, харилцан ойлголцоход хялбархан байдаг	4.1	67	14.0	89	18.5	124	25.8	90	18.8	110	22.9
Цагдаагийн байгууллагын алба хаагчид олон нийтийн газар биеэ зөв авч явж, бусдад үлгэр дуурайлал үзүүлдэг	4.0	49	10.2	91	19.0	157	32.7	83	17.3	100	20.8

Тайлбар: Огт санал нийлэхгүй – 1, Санал нийлэхгүй – 2, Дунд зэрэг – 3, Санал нийлнэ – 4, Бүрэн санал нийлнэ – 5

Эх үүсвэр: Судлаачийн SPSS 21 програмаар тооцсон дүн

Цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшилтийн үнэлгээ, тоо, хувиар, үргэлжиллэл

Хүснэгт №6

Асуултууд	Дундаж	Огт санал нийлэхгүй		Санал нийлэхгүй		Дунд зэрэг		Санал нийлнэ		Бүрэн санал нийлнэ	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Цагдаагийн алба хаагчид иргэдэд хүндэтгэлтэй хандаж, тэдэнд тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд бэлэн байдаг	4.0	31	6.5	50	10.4	199	41.5	101	21.0	91	19.0
Цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар хангалттай	4.0	51	10.6	71	14.8	102	21.3	175	36.5	81	16.9
Цагдаагийн алба хаагчид нийгмийн эмзэг бүлэг болон ахмад настай хүмүүс, хүүхдэд илүү хүндэтгэлтэй ханддаг	4.0	42	8.8	100	20.8	84	17.5	151	31.5	103	21.5
Ерөнхий дундаж	4.0	124	8.6	221	15.3	385	26.7	427	29.7	275	19.1

Тайлбар: Огт санал нийлэхгүй – 1, Санал нийлэхгүй – 2, Дунд зэрэг – 3, Санал нийлнэ – 4, Бүрэн санал нийлнэ – 5

Эх үүсвэр: Судлаачийн SPSS 21 програмаар тооцсон дүн

Дээрх хүснэгтээс харахад Улсын нийт хэмжээнд 6 дүүрэг, 4 аймгийн бүс нутгийн 480 иргэд судалгаанд оролцогчдын “Алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг” гэсэн асуултанд сэтгэл

ханамжийн дундаж үнэлгээ 4,0 буюу санал нийлдэг гэж хариулсан бол нийт судалгаанд оролцогчдын 55 иргэн буюу 11.5 хувь нь огт санал нийлэхгүй, 81 иргэн буюу 16.9 хувь нь санал нийлэхгүй, 136 иргэн буюу 28.3 хувь нь дунд зэргийн санал нийлнэ, 100 иргэн буюу 20.8 хувь нь санал нийлнэ, 108 иргэн буюу 22.5 хувь нь бүрэн санал нийлнэ гэж хариулт өгсөн байна.

“Цагдаагийн алба хаагчаас мэдээлэл авах, харилцан ойлголцоход хялбархан байдаг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 4.1 буюу санал нийлдэг гэж хариулсан бол нийт судалгаанд оролцогчдын 67 иргэн буюу 14.0 хувь нь огт санал нийлэхгүй, 89 иргэн буюу 18.5 хувь нь санал нийлэхгүй, 124 иргэн буюу 25.8 хувь нь дунд зэргийн санал нийлнэ, 90 иргэн буюу 18.8 хувь нь санал нийлнэ, 110 иргэн буюу 22.9 хувь нь бүрэн санал нийлнэ гэж хариулт өгсөн байна.

“Цагдаагийн байгууллагын алба хаагчид олон нийтийн газар биеэ зөв авч явж, бусдад үлгэр дуурайл үзүүлдэг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 4,0 санал нийлдэг гэж хариулсан бол нийт судалгаанд оролцогчдын 49 иргэн буюу 10.2 хувь нь огт санал нийлэхгүй, 91 иргэн буюу 19.0 хувь нь санал нийлэхгүй, 157 иргэн буюу 32.7 хувь нь дунд зэргийн санал нийлнэ, 83 иргэн буюу 17.3 хувь нь санал нийлнэ, 100 иргэн буюу 20.8 хувь нь бүрэн санал нийлнэ гэж хариулт өгсөн байна.

“Цагдаагийн алба хаагчид иргэдэд хүндэтгэлтэй хандаж, тэдэнд тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд бэлэн байдаг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 4.0 буюу санал нийлдэг гэж хариулсан бол нийт судалгаанд оролцогчдын 31 иргэн буюу 6.5 хувь нь огт санал нийлэхгүй, 50 иргэн буюу 10.4 хувь нь санал нийлэхгүй, 199 иргэн буюу 41.5 хувь нь дунд зэргийн санал нийлнэ, 101 иргэн буюу 21.0 хувь нь санал нийлнэ, 91 иргэн буюу 19 хувь нь бүрэн санал нийлнэ гэж хариулт өгсөн байна.

“Цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар хангалттай” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.9 буюу санал нийлдэг гэж хариулсан бол нийт судалгаанд оролцогчдын 51 иргэн буюу 10.6 хувь нь огт санал нийлэхгүй, 71 иргэн буюу 14.8 хувь нь санал нийлэхгүй, 102 иргэн буюу 21.3 хувь нь дунд зэргийн санал нийлнэ, 175 иргэн буюу 36.5 хувь нь санал нийлнэ, 81 иргэн буюу 16.9 хувь нь бүрэн санал нийлнэ гэж хариулт өгсөн байна.

“Цагдаагийн алба хаагчид нийгмийн эмзэг бүлгийн гишүүд, ахмад настай хүмүүс, хүүхдэд илүү хүндэтгэлтэй ханддаг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 4,0 буюу дунд зэрэг санал нийлдэг гэж хариулсан бол нийт судалгаанд оролцогчдын 42 иргэн буюу 8.8 хувь нь огт санал нийлэхгүй, 100 иргэн буюу 20.8 хувь нь санал нийлэхгүй, 84 иргэн буюу 17.5 хувь нь дунд зэргийн санал нийлнэ, 151 иргэн буюу 31.5 хувь нь санал нийлнэ, 103 иргэн буюу 21.5 хувь нь бүрэн санал нийлнэ гэж хариулт өгсөн байна.

Нийт судалгаанд оролцогчдын хариулсан байдлаас харахад **94.8 хувь** нь дээрх асуусан нөхцөлд санал нийлнэ гэж хариулсан байна.

ЗУРГАА.ГЭМТ ХЭРГЭЭС СЭРГИЙЛЭХ ЕРӨНХИЙ ХАНДЛАГА

Иргэд Олон нийтийн газарт мөнгө, эд зүйлсээ авч явах үедээ хулгайд алдах, оршин суудаг газартаа шөнийн цагаар ганцаараа алхах үед айх, хүүхэд, гэр бүлийн гишүүд оройтож гэртээ ирэх үед айдасыг хир зэрэг мэдэрдэг эсэхийг тогтоох зорилготойгоор судалгааг явууллаа.

6.1.Нийт судалгаанд хамрагдсан 480 иргэдийн санал асуулгын дүн

Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын гэмт хэргээс сэргийлэх ерөнхий хандлагын талаар 480 иргэн судалгаанд хамрагдсан. Асуултанд хариулсан хариултын сонголтыг 1-5 хүртэлх тоон үнэлгээгээр үнэлж судалгааг авсан.

Гэмт хэргээс сэрэмжлэх ерөнхий хандлагын талаар сэтгэл ханамжийн үнэлгээ, тоо, хувиар

Хүснэгт №7

Асуултууд	Дундаж	Огт айдасгүй байдаг		Айдасгүй байдаг		Дунд зэрэг		Айдастай байдаг		Их айдастай байдаг	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Оршин суудаг газартаа шөнийн цагаар ганцаараа алхах үед	4.3	123	25.6	99	20.6	109	22.7	100	20.8	49	10.2
Миний хүүхэд, гэр бүлийн гишүүд оройтож гэртээ ирэх үед	4.7	156	32.5	180	37.5	80	16.7	44	9.2	20	4.2
Олон нийтийн газарт мөнгө, эд зүйлс авч явах үедээ хулгайд алдах эсхүл дээрэмдүүлж болзошгүй үед	4.2	88	18.3	105	21.9	138	28.8	109	22.7	40	8.3
Ерөнхий дундаж	4.4	367	25.5	384	26.7	327	22.7	253	17.6	109	7.6

Тайлбар: Огт айдасгүй байдаг–1, Айдасгүй байдаг– 2, Дунд зэрэг – 3, Айдастай байдаг – 4, Их айдастай байдаг – 5

Эх үүсвэр: Судлаачийн SPSS 21 програмаар тооцсон дүн

Дээрх хүснэгтээс харахад 480 иргэд судалгаанд оролцогчдын **“Оршин суудаг газартаа шөнийн цагаар ганцаараа алхах үед”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 4.3 буюу дунд айдастай байдаг гэж хариулсан бол нийт судалгаанд оролцогчдын 123 иргэн буюу 25.6 хувь нь огт айдасгүй байдаг, 99 иргэн буюу 20.6 хувь нь айдасгүй байдаг, 109 иргэн буюу 22.7 хувь нь дунд зэргийн айдастай байдаг, 100 иргэн буюу 20.8 хувь нь айдастай байдаг, 49 иргэн буюу 10.2 хувь нь их айдастай байдаг гэж хариулт өгсөн байна.

“Хүүхэд, гэр бүлийн гишүүд оройтож гэртээ ирэх үед” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 4,7 буюу айдастай байдаг гэж хариулсан бол нийт судалгаанд оролцогчдын 156 иргэн буюу 32.5 хувь нь огт айдасгүй байдаг, 180 иргэн буюу 37.5 хувь нь айдасгүй байдаг, 80 иргэн буюу 16.7 хувь нь дунд зэргийн айдастай байдаг, 44 иргэн буюу 9.2 хувь нь айдастай байдаг, 20 иргэн буюу 4.2 хувь нь их айдастай байдаг гэж хариулт өгсөн байна.

“Олон нийтийн газарт мөнгө, эд зүйлс авч явах үедээ хулгайд алдах эсхүл дээрэмдүүлж болзошгүй үед” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 4,2 буюу айдастай байдаг гэж хариулсан бол нийт судалгаанд оролцогчдын 88 иргэн буюу 18.3 хувь нь огт айдасгүй байдаг, 105 иргэн буюу 21.9 хувь нь айдасгүй байдаг, 138 иргэн буюу 28.8 хувь нь дунд зэргийн айдастай байдаг, 109 иргэн буюу 22.7 хувь нь айдастай байдаг, 40 иргэн буюу 8.3 хувь нь их айдастай байдаг гэж хариулт өгсөн байна.

Нийт судалгаанд оролцогчдын хариулсан байдлаас харахад **22.7 хувь** нь дээрх асуусан нөхцөлд бага зэрэг айдастай байдаг гэж хариулсан бол **70.0 хувь** нь айдасгүй гэж хариулсан байна.

ДОЛОО.ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ СЭТГЭЛ ХАНАМЖ

Энэ хэсэг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь иргэдийн сэтгэл ханамжийг тодорхойлоход чиглэгдэнэ.

7.1.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны сэтгэл ханамжийн судалгаа

Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаар 480 иргэн судалгаанд хамрагдсан. Асуултанд хариулсан хариултын сонголтыг 1-5 хүртэлх тоон үнэлгээгээр үнэлж судалгааг авсан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаан дахь иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ, тоо, хувиар Хүснэгт №8

Асуултууд	Дундаж	Огт санал нийлэхгүй		Санал нийлэхгүй		Дунд зэрэг		Санал нийлнэ		Бүрэн санал нийлнэ	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Би цагдаагийн байгууллагад хандаж үйлчлүүлээд сэтгэл ханамж өндөр байсан	4.0	40	8.3	53	11.0	91	19.0	126	26.3	180	37.5
Би эсхүл миний гэр бүлийн гишүүд гэмт хэрэг, халдлагад өртсөн тохиолдолд ямар ч эргэлзээгүйгээр	4,1	20	4.2	47	9.8	90	18.8	116	24.2	207	43.1

цагдаагийн байгууллагад ханддаг											
Манай цагдаа намайг хамгаална гэж би итгэдэг	4,0	14	2.9	30	6.3	86	17.9	100	20.8	250	52.1
Ерөнхий дундаж	4,0	74	5.1	130	9.0	267	18.5	342	23.8	637	44.2

Тайлбар: Огт санал нийлэхгүй – 1, Санал нийлэхгүй – 2, Дунд зэрэг – 3, Санал нийлнэ – 4, Бүрэн санал нийлнэ – 5

Эх үүсвэр: Судлаачийн SPSS 21 програмаар тооцсон дүн

Дээрх хүснэгтээс харахад судалгаанд оролцогчдын **“Би цагдаагийн байгууллагад хандаж үйлчлүүлээд сэтгэл ханамж өндөр байсан”** гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 4,0 буюу цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байдаг гэж хариулсан бол нийт судалгаанд оролцогчдын 40 иргэн буюу 8.3 хувь нь огт санал нийлэхгүй, 53 иргэн буюу 11.0 хувь нь санал нийлэхгүй, 91 иргэн буюу 19.0 хувь нь дунд зэргийн санал нийлнэ, 126 иргэн буюу 26.3 хувь нь санал нийлнэ, 180 иргэн буюу 37.5 хувь нь бүрэн санал нийлнэ гэж хариулт өгсөн байна.

“Би эсхүл миний гэр бүлийн гишүүд гэмт хэрэг, халдлагад өртсөн тохиолдолд ямар ч эргэлзээгүйгээр цагдаагийн байгууллагад ханддаг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 4,1 буюу цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байдаг гэж хариулсан бол нийт судалгаанд оролцогчдын 20 иргэн буюу 4.2 хувь нь огт санал нийлэхгүй, 47 иргэн буюу 9.8 хувь нь санал нийлэхгүй, 90 иргэн буюу 18.8 хувь нь дунд зэргийн санал нийлнэ, 116 иргэн буюу 24.2 хувь нь санал нийлнэ, 207 иргэн буюу 43.1 хувь нь бүрэн санал нийлнэ гэж хариулт өгсөн байна.

“Манай цагдаа намайг хамгаална гэж би итгэдэг” гэсэн асуултанд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 4,0 буюу цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байдаг гэж хариулсан бол нийт судалгаанд оролцогчдын 14 иргэн буюу 2.9 хувь нь огт санал нийлэхгүй, 30 иргэн буюу 6.3 хувь нь санал нийлэхгүй, 86 иргэн буюу 17.9 хувь нь дунд зэргийн санал нийлнэ, 100 иргэн буюу 20.8 хувь нь санал нийлнэ, 250 иргэн буюу 52.1 хувь нь бүрэн санал нийлнэ гэж хариулт өгсөн байна.

Нийт судалгаанд оролцогчдын хариулсан байдлаас харахад **92.3 хувь** нь дээрх асуусан нөхцөлд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай санал нийлнэ гэж хариулсан байна.


НАЙМ.ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Цагдаагийн байгууллага 2022 оны эхний 6 сард иргэн, хуулийн этгээдээс 318 904 дуудлага, мэдээлэл хүлээн авч хуульд заасны дагуу шалган шийдвэрлэсэн байна. Гэмт хэрэг зөрчлийн шинжтэй 160 837 гомдол, мэдээлэл хүлээн авч

шалгасан нь өмнөх оны мөн үеийнхээс 45 526 буюу 39.5 хувиар өсч, гэрм хэргийн шинжтэй 46 529 буюу 28.9 хувь, зөрчлийн шинжтэй 108 328 буюу 67.4 хувь гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт

Зураг №5



Гомдол, мэдээлэлийн шийдвэрлэлтэд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 34.0 хувь, хэрэг нээхээс татгалзсан 65.2 хувь, харьяаллын дагуу шилжүүлсэн 0.8 хувийг тус тус эзлэж байна.

Зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт

Зураг №6




Хувиар үзүүлбэл:
Зөрчлийн хэрэг нээсэн 73.6 хувь, зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан нь 25.7 хувь, харьяаллын дагуу шилжүүлсэн нь 0.7 хувийг тус тус эзлэж байна.

Гэмт хэргийн илрүүлэлт

Улсын хэмжээнд 48.7 хувь, нийслэлд 48.9 хувь, орон нутагт 48.3 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс улсын хэмжээнд 4.5 нэгж, нийслэлд 5.5 нэгж, орон нутагт 1.9 нэгжээр тус тус өссөн байна.

Зураг №7



Хэрэг бүртгэлтийн хэрэг

Хэрэг бүртгэлтийн 16 881 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны үетэй харьцуулбал 100 58 хэрэг буюу 2.5 дахин, үүнээс 8229 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан нь 5211 буюу 2.7 дахин тус тус өссөн байна.

ЕС.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, цагдаагийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний сэтгэл ханамжийн талаар иргэдээс цахимаар болон анкетын аргаар авсан судалгааны дүнг дараах байдлаар нэгтгэн дүгнэж байна:

Хүснэгт №9

Судалгааны агуулга	Хувь
Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн судалгааны дүн	90.1
Цагдаагийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшлийн судалгааны дүн	94.8
Гэмт хэргээс сэргийлэх ерөнхий хандлагын дүн	92.7
Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны сэтгэл ханамжийн судалгааны дүн	92.3
Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны статистик үзүүлэлтийн дүн	90.0
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн дүн	96.6
Нийт дундаж	92.75

Жич: Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2022 онд хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй

байдлыг хангах, улсын онц чухал объектыг хамгаалах үндсэн чиг үүрэг, дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэв.

Цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүн **92.75 хувь буюу 4.6 оноотой** гарсан нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамж өндөр байгааг харуулж байгаа ба иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны дүн өмнөх оноос 0.75 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.

Нөлөөлсөн хүчин зүйл:

-Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлын алба нь 2022 оны эхний хагас жилд Цагдаагийн албаны тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажилласан байна;

-Эргүүлийн нэгдсэн байршилтыг цахимд шилжүүлэн, хяналтад авснаар эргүүлийн үйл ажиллагааг оновчтой зохион байгууж, хүн, хүч хэрэгслийг зөв байршуулсан байна;

-Улсын хэмжээнд анх удаа олон нийтэд чиглэсэн “Зөвийг зөвлөө” нөлөөллийн арга хэмжээг төсөв, хөрөнгө шаардахгүйгээр хэвлэл мэдээллийн байгууллага, цахим орчин болон бусад аж ахуй нэгжийн нийгмийн оролцоонд тулгуурлан зохион байгуулсан нь иргэд, олон нийтэд хүрсэн бодит ажил болсон байгааг тэмдэглэн хэлэх нь зүйтэй.

Цаашид хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэгт хамаарах гудамж талбай, олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 2.0 дахин, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 48.6 хувиар тус тус өссөн сөрөг үзүүлэлттэй байгааг анхааран ажиллах;

Улсын хэмжээнд бүртгэгдсэн зарим төрлийн гэмт хэрэг урьд оны мөн үетэй харьцуулахад тодорхой хэмжээнд өссөн үзүүлэлттэй байгаад дүгнэлт хийж, гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэлтийг ахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулж, үр дүнг тооцох нь зүйтэй гэж үзлээ.

--oOo--

Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний судалгааны асуулга

Судалгааны зорилго: Энэхүү судалгааны зорилго нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэх хэрэглэгчийн сэтгэл ханамжийг тодорхойлоход оршино. Судалгааны үр дүн нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чанар, хүртээмжийг дээшлүүлэх, хэрэглэгчийн үнэлгээний аргачлал боловсруулахад ашиглагдах бөгөөд нууцлалыг хадгална.

Бидэнтэй хамтран ажиллаж, цаг гарган оролцсон танд чин сэтгэлээсээ талархал илэрхийлье.

Та асуулт бүрийг анхааралтай уншаад сонгосон хариултынхаа тохирох тоог дугуйлна уу?

***Бүх хариулт таны өнгөрсөн 2 жилийн хугацаанд хамрагдахыг анхаарна уу!!!

Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргийн талаар

Цагдаагийн байгууллагын үндсэн чиг гэдэгт гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажил багтах бөгөөд энэ хэсэгт орон нутгийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чиг үүргийн хэрэгжилтийг тодорхойлно.

	Огт санал нийлэхгүй	Санал нийлэхгүй	Дунд зэрэг	Санал нийлнэ	бүрэн санал нийлнэ
Цагдаагийн байгууллагад гэмт хэргийн талаар дуудлага, мэдээлэл өгсөн тохиолдолд аль болох богино хугацаанд хүрэлцэн ирдэг					
Гэмт хэрэг үйлдэгдсэн талаар цагдаагийн байгууллагад мэдээлсэн тохиолдолд гэмт этгээдийг заавал олж баривчилдаг					
Ноцтой гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цагдаагийн байгууллага түргэн шуурхай илрүүлдэг					
Цагдаагийн алба хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хангалттай зохион байгуулдаг бөгөөд үр дүнтэй байдаг					
Орон нутгийн хэмжээнд гэмт хэргийг таслан зогсоох ажиллагааг цагдаа үр дүнтэй хэрэгжүүлдэг					
Цагдаагийн алба хаагч хэв журам сахиулах зорилгоор манай нутаг дэвсгэрт эргүүлийн үүрэг маш сайн гүйцэтгэдэг					
Цагдаа орон нутгийн хэмжээнд зохион байгуулдаг олон нийтийг хамарсан спорт, урлаг, баяр наадам, жагсаал цуглааныг зохицуулах, аюулгүй байдлыг хангах үүргээ сайн гүйцэтгэдэг					

Цагдаагийн алба хаагч замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд үр дүнтэй хэрэгжүүлдэг					
---	--	--	--	--	--

Цагдаадгийн алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн төлөвшил
 Доорх асуултууд нь таны оршин сууж буй нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын алба хаагчдын ёс зүй, харилцааны соёлыг тодорхойлоход чиглэгдэнэ.

	Огт санал нийлэхгүй	Санал нийлэхгүй	Дунд зэрэг	Санал нийлнэ	бүрэн санал нийлнэ
Алба хаагчид харилцааны өндөр соёлтой, стандарт дүрмээ баримтлан ажилладаг					
Цагдаагийн алба хаагчаас мэдээлэл авах, харилцан ойлголцоход хялбархан байдаг					
Цагдаагийн байгууллагын алба хаагчид олон нийтийн газар бие зөв авч явж, бусдад үлгэр дурайлал үзүүлдэг					
Цагдаагийн алба хаагчид иргэдэд хүндэтгэлтэй хандаж, тэдэнд тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд бэлэн байдаг					
Цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар хангалттай					
Цагдаагийн алба хаагчид нийгмийн эмзэг бүлгийн гишүүд, ахмад настай хүмүүс, хүүхдэд илүү хүндэтгэлтэй ханддаг					

Гэмт хэргээс сэрэмжлэх ерөнхий хандлага
 Та дор дурдсан нөхцөл тус бүрт хэр зэрэг айдсыг мэдэрдэг бэ ?

	Огт айдасгүй байдаг	Айдасгүй байдаг	Дунд зэрэг	Айдаст ай байдаг	Их Айдастай байдаг
Оройн цагаар гэртээ ганцаараа байх үедээ					
Оршин суудаг газартаа шөнийн цагаар ганцаараа алхах үед					
Миний хүүхэд, гэр бүлийн гишүүд оройтож гэртээ ирэх үед					
Олон нийтийн газарт мөнгө, эд зүйлс авч явах үедээ хулгайд алдах эсхүл дээрэмдүүлж болзошгүй гэж					

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дахь сэтгэл ханамж
 Энэ хэсэг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа дахь тань сэтгэл ханамжийг тодорхойлоход чиглэгдэнэ

	Огт санал нийлэхгүй	Санал нийлэхгүй	Дунд зэрэг	Санал нийлнэ	бүрэн санал нийлнэ
Б и ц а г д а а г и й н б а й г у у л л а г а д х а н д а ж ү й л ч л ү ү л э э д с э т г э л х а н а м ж ө н д ө р б					

а й с а н					
Б и э с х ү л м и н и й г э р б ү л и н г и ш ү ү д г э м т х э р э г , х а л д л а г а д ө р т с ө н т о х и о					

Л Д О Л Д Я М А Р Ч Э Р Г Э Л З Э Э Г Ү Й Г Э Э Р Ц А Г Д А Г И Й Н Б А Й Г У У Л Л А Г А Д Х А Н Д Д А Г					
М А Н А Й Ц А Г Д					

а а н а м а й г х а м г а л н а г э ж б и и т г э д э г					
--	--	--	--	--	--

] Таны боловсролын түвшин.			
<input type="radio"/> Боловсролгүй	<input type="radio"/> ① Бага	<input type="radio"/> ② Бүрэн бус дунд	<input type="radio"/> ③ Бүрэн дунд
	<input type="radio"/> ④ Дээд		

Таны хүйс?	
<input type="radio"/> ① Эрэгтэй	<input type="radio"/> ② Эмэгтэй
Нас?	
гэрлэлтийн байдал?	
<input type="radio"/> ① Гэрлээгүй	<input type="radio"/> ② Гэрлэсэн

Таньд баярлалаа